Тайлан бэлтгэсэн:

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер:
Х.Түвшинбаяр

Аудитын менежер:

С.Гантөгс

Ахлах аудитор:

Н.Бадамхатан
Н.Баттоогоо
Б.Цолмон
Д.Мөнхдэлгэр

Аудитор:

Н.Одончимэг
З.Мөнхзаяа
Б.Тэгш-лхам
Ш.Мөнхжаргал
Ц.Цэнд-Аюуш
Д.Эрдэнэбулган
Т.Мөнхцацрал
М.Өлзийхишиг

2026 оны 4 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү:
www.open.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 327734 дугаар утсаар харилцана уу.

ХАЯГ:
Нийслэл дэх Төрийн аудитын газар
Нийслэлийн өмчийн 1-р байр,
Улаанбаатар хот.
Монгол Улс

## АГУУЛГА

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ ....4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН ....6
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН ....6
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН ....7
2.3 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН ....7
3. АУДИТЫН ТАЙЛАН ....10
3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ ....10
3.1.1 Аудит хийсэн үндэслэл ....10
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ ....10
3.1.3 Аудитын арга зүй ....10
3.1.4 Материаллаг байдлын түвшин ....10
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ ....10
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж ....11
3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн ....11
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ....12
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ ....13
4.2 АВЛАГА ....17
4.3 УРЬДЧИЛГАА ....19
4.4 БАРАА МАТЕРИАЛ ....20
4.4.1 НӨӨЦИЙН БАРАА ....23
4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ ....23
4.7 ҮНДСЭН ХӨРӨНГӨ ....24
4.9 ӨР ТӨЛБӨР ....30
4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО ....34
4.11 НТЕЗ-ИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....35
Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит ....36
Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит ....38
Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит ....38
4.12 НТЕЗ-ИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА ....41
4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ....41
4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ....42
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ,ЗӨВЛӨМЖ ....43

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ААТҮГ | Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| АТХБХТөв | Авто тээврийн хэрэгслийг бүртгэх хяналтын төв |
| БНД | Багануур дүүрэг |
| БХД | Багахангай дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БГД | Баянгол дүүрэг |
| БГШӨ | Баянгол Шинэ өргөө |
| БЗШ | Баянзүрх Шижир |
| БГЦХ | Баянгол цэцэрлэгт хүрээлэн |
| БГТ | Баянгол тохижилт |
| БТҮ | Баянгол тохижилт үйлчилгээ |
| ГХУСАЗНСЗ | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Нийслэлийн салбар зөвлөл |
| ГУББГ | Геодези усны барилга байгууламжийн газар |
| ГТҮТ | Гэрэлтүүлэг тохижилт үйлчилгээний тасаг |
| ДАА | Дотоод аудитын алба |
| ДТЦС | Дулааны тавдугаар цахилгаан станц |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЗХУТ | Замын хөдөлгөөний удирдлагын төв |
| ЗД | Засаг дарга |
| ЖДҮДТ | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МУЗГ | Монгол улсын Засгийн газар |
| НАОБТГ | Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газар |
| НОК | Нийслэлийн онцгой комисс |
| НЗАА | Нийслэлийн Захирагчийн ажлын алба |
| ННҮГ | Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар |
| НИТХ | Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НТАГ | Нийслэлийн төрийн аудитын газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НДАА | Нийслэлийн Дотоод аудитын алба |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| НХААГ | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НЖДҮҮДТ | Нийслэлийн Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв |
| НЗХГ | Нийслэлийн Замын хөгжлийн газар |
| НХОГ | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар |
| ННЗЦБ | Нийслэлийн Нутгийн захиргааны цогцолбор барилга |
| НӨҮГ | Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газар |
| НОСК | Нийслэлийн Орон сууцны корпораци |
| НҮ | Нийтлэг үйлчилгээ |
| НД | Налайх дүүрэг |
| НТХО | Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалт |
| НӨХГ | Нийслэлийн Өмчийн харилцааны газар |
| НХХААГ | Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газар |
| НХТГ | Нийслэлийн Хот тохижилтын газар |
| НАТХБХТ | Нийслэлийн Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв |
| НЭУС | Нийслэлийн Эрсдэлийн удирдлагын сан |
| НГБДС | Нийслэлийн Гарааны бизнес дэмжих сан |
| НХЗСХТЦ | Нийслэлийн Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор |
| НБОГ | Нийслэлийн Байгаль орчны газар |
| НЗХГ | Нийслэлийн Замын хөгжлийн газар |
| НЕТГ | Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар |
| НТЗАБ | Нийслэлийн Төр захиргааны авто бааз |
| НЭЗТЦ | Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ |

| | |
|---|---|
| НБЗЗАГ | Нийслэлийн Баруун бүсийн зам засвар арчлалтын газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| *ОСНААУГ* | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| *ОУЭЦХ* | Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн |
| *ОУХЛТ* | Олон улсын худалдаа логистикийн төв |
| ОНӨААН | Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж |
| СУЁХО | Соёл урлаг ёслол хүндэтгэлийн ордон |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТКХТ | Телекамерын хяналтын төв |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ТХҮТ | Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв |
| УБХОМ | Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| УСУГ | Ус сувгийн удирдах газар |
| УБСК | Улаанбаатар смарт карт |
| УБОС | Улаанбаатар орон сууцжуулалт |
| УССТ | Усан спорт сургалтын төв |
| УБЗЗАГ | Улаанбаатар зам засвар арчлалтын газар |
| УСБТ | Усан спорт боулингийн төв |
| УХНТНС | Улаанбаатар хотын нийтийн төв номын сан |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ҮИГ | Үйлдвэрлэл инновацийн газар |
| ҮЦХ | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХК | Хувьцаат компани |
| ХНӨ | Хүүхдийн номын өргөө |
| ХУБТ | Хүүхдийн урлан бүтээх төв |
| ХОББДТ | Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв |
| ХОС | Хөрөнгө оруулалтын сан |
| ХХААХҮЯ | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| ХОББТ | Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт төв |
| ХААА | Худалдан авах ажиллагааны алба |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ХИХУГ | Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ШШГГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |
| ЭЭАҮП | Эмээлт эко аж үйлдвэрийн парк |
| ЭХҮТП | Эмээлт хөнгөн үйлдвэрлэл технологийн парк |

# 1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.20 № 1054

танай ________ -ны № ________ -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 201, 264 ,265 дугаар тогтоолуудаар Нийслэлийн Засаг дарга нийт 2,508.4 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргасан бөгөөд 2025 онд 1,062.7 тэрбум төгрөг буюу 42.4 хувийг зарцуулсан байна. Бондын үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрт нийт 302.7 тэрбум төгрөг төлсөн бөгөөд үүнээс 78.5 хувь буюу 237.7 тэрбум төгрөгийг Нийслэлийн өрийн үйлчилгээний төлбөрийн зардлаас, 13.9 хувь буюу 42.0 тэрбум төгрөгийг Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төслийн орлогын эх үүсвэрээс, 7.6 хувь буюу 23.0 тэрбум төгрөгийг Батарей хуримтлуурын төслийн орлогын эх үүсвэрээс тус тус төлсөн байна.

## Аудитын гол асуудал

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 тогтоолоор Нийслэлийн 2025 онд зарцуулах нийт зарлагыг 5,957.7 тэрбум төгрөгөөр баталж,

1428052046
C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

түүнд 4 удаа тодотгол хийж, 1,390.2 тэрбум төгрөгөөр буюу 23.3 хувиар бууруулан 4,567.5 тэрбум төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 4,526.2 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 34.6 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08, 2025 оны 25/111 дүгээр тогтоолуудаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт томоохон 16 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Дээрх бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн 2025 оны гүйцэтгэл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хэрэгжилтийг авч үзвэл 10 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 4 төсөл арга хэмжээ 80.0 хувийн, 2 төсөл арга хэмжээ 40.0-өөс бага хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, холбогдох мэдээлэлтэй танилцсан. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон *(мянган төгрөгөөр)*

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,121,455,747.2** | **5,629,231,133.8** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3,249,337,431.4 | 2,604,681,943.7 |
| 32 | БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 2,450,000.0 | 1,869,061.2 |
| 33 | АВЛАГА | 264,568,578.2 | 222,580,703.6 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 67,397,401.5 | 95,674,149.7 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 87,338,637.5 | 128,165,447.3 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 1,129,870.9 | 359,288.4 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 1,449,233,827.8 | 2,575,900,539.9 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,626,823,152.9** | **4,230,349,696.0** |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 300,175,955.9 | 300,002,626.8 |
| 37300 | Урт хугацаат зээл | 300,175,955.9 | 300,002,626.8 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,326,647,197.0 | 3,930,347,069.2 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,879,957,000.1 | 2,337,089,840.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 1,203,813,706.2 | 1,334,118,961.9 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 242,876,490.6 | 259,138,266.8 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **8,748,278,900.1** | **9,859,580,829.8** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,868,636,604.0** | **4,587,386,444.4** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **290,405,496.2** | **322,095,072.7** |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг | 128,345.1 | 4,112,817.0 |
| 41300 | Өглөг | 173,194,336.2 | 224,260,791.7 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 117,082,814.9 | 93,721,464.1 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **3,578,231,107.7** | **4,265,291,371.7** |
| 42100 | Урт хугацаат үнэт цаас | 2,508,396,215.1 | 2,461,743,161.9 |
| 42200 | Урт хугацаат зээл | 1,069,834,892.6 | 1,803,548,209.8 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,879,642,296.2** | **5,272,194,385.4** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,879,642,296.2** | **5,272,194,385.4** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 996,624,015.8 | 999,125,718.5 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 840,154,523.7 | 946,117,230.1 |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/ | - | 167,246.6 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 749,857,141.2 | 886,005,091.2 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,886,152,735.3 | 2,043,065,192.1 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 406,853,880.2 | 397,713,906.9 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **8,748,278,900.1** | **9,859,580,829.8** |

## 2.2 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон *(мянган төгрөгөөр)*

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,085,829,055.1** | **4,759,450,997.7** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **2,804,557,119.4** | **3,210,667,835.3** |
| **110** | **Орлогын албан татвар** | 2,375,572,886.2 | 2,701,318,647.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,712,715,359.7 | 1,935,352,695.9 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (47,142,473.5) | (52,466,938.2) |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 710,000,000.0 | 818,432,889.8 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 156,825,106.1 | 235,502,337.7 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 272,159,127.1 | 273,846,850.2 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,256,477,082.7** | **1,548,783,162.3** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,042,236,198.9 | 1,459,699,851.0 |
| 121 | Хөрөнгийн орлого | 166,198,320.0 | 3,904,444.3 |
| 122 | Тусламжийн орлого | - | 55,018,273.1 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 48,042,563.8 | 30,160,594.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **24,794,853.0** | **-** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,670,292,149.5** | **3,578,567,556.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,670,292,149.5** | **3,557,280,991.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,221,967,308.6** | **2,972,133,390.1** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 349,341,001.7 | 573,281,012.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 37,740,559.3 | 83,052,659.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 110,831,866.5 | 161,280,624.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 341,649,289.3 | 304,262,727.5 |
| 2105 | Нормативт зардал | 3,688,050.6 | 4,403,669.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 51,813,283.5 | 56,067,456.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,617,496.5 | 7,453,090.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 503,097,538.5 | 617,886,664.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 815,188,222.7 | 1,164,445,485.3 |
| 211 | ХҮҮ | 77,421,242.6 | 244,668,594.7 |
| 212 | ТАТААС | 324,248,862.3 | 187,595,818.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 46,654,736.0 | 152,883,187.3 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 21,286,565.4 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,415,536,905.6** | **1,180,883,441.3** |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 7,724,461.4 | 13,669,837.9 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,237,430,698.5 | 1,246,313,486.5 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **185,830,668.5** | **(51,760,207.3)** |

## 2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон *(мянган төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,875,366,207.4** | **3,875,366,207.4** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 434,412,951.8 | 434,412,951.8 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,309,779,159.2** | **4,309,779,159.2** |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (28,828,236.7) | (28,828,236.7) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 414,473,089.9 | 414,473,089.9 |
| Зарласан ногдол ашиг | (1,612,384.8) | (1,612,384.8) |
| Тайлант үеийн үр дүн | 185,830,668.62 | 185,830,668.6 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,879,642,296.2** | **4,879,642,296.2** |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **4,879,642,296.2** | **4,879,642,296.2** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 206,775,592.7 | 206,775,592.7 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,086,417,888.9** | **5,086,417,888.9** |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (7,711,608.7) | (7,711,608.7) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 246,607,425.1 | 246,607,425.1 |
| Зарласан ногдол ашиг | (1,359,112.5) | (1,359,112.5) |
| Тайлант үеийн үр дүн | (51,760,207.3) | (51,760,207.3) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,272,194,385.5** | **5,272,194,385.5** |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон *(мянган төгрөгөөр)*

| КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,038,076,574.1** | **4,890,644,445.3** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **2,804,557,119.4** | **3,210,667,835.3** |
| **110** | **Орлогын албан татвар** | **2,375,572,886.2** | **2,701,318,647.5** |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,712,715,359.7 | 1,935,352,695.9 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (47,142,473.5) | (52,466,938.2) |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 710,000,000.0 | 818,432,889.8 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 156,825,106.1 | 235,502,337.7 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **272,159,127.1** | **273,846,850.2** |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 79,708,738.0 | 90,923,298.6 |
| 1181 | Газрын төлбөр | 158,489,295.7 | 140,066,212.9 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 4,324,779.9 | 4,671,511.9 |
| 1183 | Бусад татвар | 29,636,313.4 | 38,185,826.8 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,208,536,802.6** | **1,679,976,610.0** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,159,885,838.8 | 1,581,843,104.1 |
| 121 | Хөрөнгийн орлого | 608,400.0 | 3,904,444.3 |
| 122 | Тусламжийн орлого | - | 55,068,467.6 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 48,042,563.8 | 39,160,594.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **24,982,652.0** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,220,922,816.2** | **3,277,234,870.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,220,922,816.2** | **3,277,234,870.9** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,791,989,683.2 | 2,593,993,982.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 418,933,050.8 | 606,032,031.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 83,457,886.8 | 96,767,899.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 122,837,896.2 | 157,604,654.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 288,598,984.0 | 372,137,186.0 |
| 2105 | Нормативт зардал | 3,052,373.0 | 2,823,475.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 46,658,450.7 | 45,148,032.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,976,929.2 | 6,675,200.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 610,075,072.9 | 1,099,537,933.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 210,399,039.5 | 207,267,568.7 |
| 211 | ХҮҮ | 59,548,079.5 | 325,376,240.8 |
| 212 | ТАТААС | 323,243,305.1 | 183,918,287.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 46,141,748.4 | 173,946,360.5 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,817,153,757.9** | **1,613,409,574.4** |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 29,466.5 | 200,169.9 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,947,743,305.2 | 2,172,154,334.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,947,743,305.2 | 2,172,154,334.2 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,947,743,305.2 | 2,172,154,334.2 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (1,947,713,838.8) | (2,171,954,164.4) |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | 2,361,991,438.5 | (86,110,897.7) |
| 14 | Бусад эх үүсвэр | 2,516,901,920.8 | 17,646,054.8 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 109,558,995.2 | 54,345,120.9 |
| 24 | ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР | - | - |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 45,351,487.2 | 49,411,831.6 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **2,231,431,357.6** | **(644,655,487.6)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,017,906,073.7 | 3,249,337,431.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,249,337,431.3 | 2,604,681,943.7 |

# 3. АУДИТЫН ТАЙЛАН

## 3.1. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### 3.1.1. Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

### 3.1.2. Аудитын зорилт, хамарсан хүрээ

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.
Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын болон Төсвийн тухай хуулийн дагуу төсөв захирагчид, төсөл, сан, зардал, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

### 3.1.3. Аудитын арга зүй

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

### 3.1.4. Материаллаг байдлын түвшин

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, зардал, сан, төсөл, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн бөгөөд материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 8,748,278.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 131,224.2 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

## 3.2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-д заасны дагуу Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хүргүүлсэн тухай НЗД-

ын 2026 оны 4 сарын 1-ний өдрийн 1/1945 дугаар албан бичгийг e-doc системд цахимаар ирүүлсэн. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг цаасаар баталгаажуулан, НТАГ-т 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд ТТЗ болон ТШЗ-дын хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан нийт 198,377.3 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд, 1,627,683.3 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 9,116,899.8 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан;
- Тодруулга тайлангаар өмнөх оны болон тайлант оны үлдэгдлийг байгууллагаар нь дэлгэрэнгүйгээр толилуулсан;

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 9 дүүргийн ТТЗ, тэдгээрийн харьяа ТШЗ 75, орон нутгийн өмчит 55, зардал сан 9, нийт 148, нийслэлийн орон нутгийн ТШЗ 28, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой 52 хуулийн этгээд, төслийн нэгж, сан, зардлын 8 данс, ТЕЗ-ийн 2, нийт 238 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

### 3.2.1. Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

### 3.2.2. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны "Э-тайлан" программаар нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

***Хүснэгт №1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц***

| А. Үндсэн тайлан | Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан | В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга |
|---|---|---|
| Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд |
| Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | 1а, 1б, 2а, 2б тодруулга |
| Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | |
| Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | |

## 3.3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

### 3.3.1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 9,859,580.8 сая төгрөг болж, өмнөх оноос 12.7 хувиар нэмэгдсэн байна.

***Хүснэгт №2. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч***

*/сая төгрөгөөр/*

| Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 5,121,455.7 | 5,629,231.1 | 507,775.4 | 45.7 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 3,626,823.2 | 4,230,349.7 | 603,526.5 | 54.3 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **8,748,278.9** | **9,859,580.8** | **1,111,301.9** | **100.0** |
| Нийт өр төлбөр | 3,868,636.6 | 4,587,386.4 | 718,749.8 | 64.7 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 4,879,642.3 | 5,272,194.4 | 392,552.1 | 35.3 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **8,748,278.9** | **9,859,580.8** | **1,111,301.9** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт хөрөнгө өмнөх оноос 1,111,301.9 сая төгрөгөөр өсөхөд урьдчилгаа, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд:

- Урьдчилгаа дансанд Баянзүрх дүүрэгт шинэ замын ажлын урьдчилгаанд 12,082.6 сая төгрөг, Хан-уул дүүргийн хөрөнгө оруулалтын ажлын урьдчилгаанд 18,574.8 сая төгрөг, УСУГ ОНӨААТҮГ-ын цэвэр усны шугамын хөрөнгө оруулалт, урсгал болон их засварын ажлын урьдчилгаанд 18,010.9 сая төгрөг төлснөөр тус тус нэмэгдсэн;
- Бараа материалын дансанд УБЗЗАГ ОНӨААТҮГ-ын хийж гүйцэтгэсэн ажлуудыг БЗД-ын ЗДТГ-т 5,702.7 сая төгрөг, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр агаарын чанарыг сайжруулах, гэр хорооллын бүсийн айл өрхөд стандартад нийцсэн давхар шаталтат зуух суурилуулан СХД-ийн ЗДТГ-т 20,207.1 сая төгрөг, ХХААХҮЯ-аас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулагдсан Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр үнэ төлбөргүй ирсэн бэлэн бүтээгдэхүүн, сэлбэгийг НЖДҮҮДТ НӨҮГ-т 2,777.7 сая төгрөгийг бүртгэснээр тус тус нэмэгдсэн;
- Бусад эргэлтийн хөрөнгө дансанд Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.4 дэх заалтын дагуу нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй шилжүүлэх зориулалттай дуусаагүй болон он дамжин хэрэгжих ажлуудыг бүртгэсэн байна. Тухайлбал, НЗХГ-т он дамжин хэрэгжих Туулын хурдны замын ажлын урьдчилгаа 401,000.0 сая төгрөг, НХОГ-т Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ажлын үлдэгдэл 104,716.3 сая төгрөг, Наркологийн эмнэлгийн барилгын 20,077.7 сая төгрөг, Сэлбэ 20 минутын хот корпорац ХХК-ийн Сэлбэ дэд төв төслийн 293,615.5 сая төгрөгийг бүртгэснээр тус тус нэмж бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгө дансанд УБ хотын Хөгжлийн корпорац ХХК-ийн охин компани болох Улаанбаатар Энержи ХХК нь “Багануур батарей хуримтлуурын станц”-ын 220/110/35 кВт-ын дэд станцын хуваарилах байгууламжийн өргөтгөл, эрчим хүчний тоног төхөөрөмж 286,141.0 сая төгрөг, Зорчигч тээвэр-2 ОНӨААТҮГ нь НЗД-ын 2025 оны А/1349 дүгээр захирамжаар Skyworth загварын автобус 10,836.7 сая

төгрөг, НЗД-ын 2025 оны А/688 дугаар захирамжаар Yutong загварын их багтаамжийн автобус 14,809.4 сая төгрөг, ТЦХ ХХК нь 12,661 м.кв газрыг 17,833.7 сая төгрөг, НД-ийн ЗДТГ нь 4,439,721 м.кв газрыг 102,705.6 сая төгрөгөөр үнэлж, бүртгэснээр тус тус нэмэгдсэн;

### 3.3.2. Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 51,760.2 сая төгрөгийн сөрөг үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Төсөвт байгууллагууд нийт 615,583.4 сая төгрөгийн эерэг */орлого нь зардлаасаа их/* үр дүнтэй;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд нийт 11,378.3 сая төгрөгийн алдагдалтай, Төрийн сан нийт 652,136.5 сая төгрөгийн, төсөл сан 3,828.8 сая төгрөгийн сөрөг */орлого нь зардлаасаа бага/* үр дүнтэй тайлагнасан байна.

### 3.3.3. Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 392,552.1 сая төгрөгөөр өссөн, тайлант үеийн үр дүн өмнөх оноос 134,070.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

### 3.3.4. Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлогыг 4,890,644.4 сая төгрөг, мөнгөн зарлагыг 3,277,234.9 сая төгрөгөөр, цэвэр мөнгөн гүйлгээг 644,655.5 сая төгрөгийн сөрөг үзүүлэлттэй илэрхийлж, оны эцэст 2,604,682.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 4.1. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,604,682.0 сая төгрөг болж, өмнөх оноос 644,655.5 сая төгрөгөөр буурсан байна.

***Хүснэгт №3. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр***

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 264.1 | 526.7 | 262.6 | 0.02 |
| Төрийн сангийн дахь харилцах | 1,087,196.3 | 784,227.0 | (302,969.3) | 30.10 |
| Арилжааны банк дахь харилцах | 172,804.7 | 225,764.5 | 52,959.8 | 8.70 |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 317,939.0 | 26,755.7 | (291,183.3) | 1.03 |
| Хадгаламж | 1,671,133.3 | 1,567,408.0 | (103,725.3) | 60.20 |
| **Дүн** | **3,249,337.4** | **2,604,681.9** | **(644,655.5)** | **100.0** |
| ***Үүнээс: Байгууллагын төрлөөр:*** | | | | |
| Төрийн сан | 2,886,144.4 | 2,203,183.8 | (682,960.6) | 84.60 |
| Орон нутгийн төсвийн байгууллага | 132,886.7 | 83,082.5 | (49,804.2) | 3.20 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 229,835.6 | 281,172.7 | 51,337.1 | 10.80 |
| Төсөл сан | 470.7 | 37,242.9 | 36,772.2 | 1.40 |
| **Дүн** | **3,249,337.4** | **2,604,681.9** | **(644,655.5)** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн бууралтад Нийслэлийн харьяа байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 638,344.4 сая төгрөг, СБД 21,045.5 сая төгрөг, БГД 17,674.0 сая төгрөг, СХД 11,899.6 сая төгрөгөөр тус тус буурч, БЗД 22,623.9 сая төгрөгөөр, ЧД 16,490.6 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 89.5 хувийг Нийслэлийн харьяа байгууллагуудын, 10.5 хувийг дүүргүүдийн үлдэгдэл эзэлж байна. Дүүргүүдийн хувьд төсвийн орлогын төлөвлөгөө биелээгүйтэй холбоотой төрийн сангийн үлдэгдэл буурсан байна. Нийт мөнгөн хөрөнгийн 0.02 хувь нь кассад, 98.95 хувь нь арилжааны банканд, 1.03 хувь нь замд яваа мөнгөн хөрөнгө хэлбэрээр байршиж байна.

Кассад байгаа бэлэн мөнгө 262.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд Нийслэлийн харьяа байгууллагуудын орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад 238.2 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна. Энэ нь нийслэлд 8 ОНӨААТҮГ, 4 ХХК шинээр байгуулагдсантай холбоотой байна.

Банканд байгаа бэлэн мөнгөний 30.4 хувь буюу 784,227.0 сая төгрөг нь Төрийн сангийн харилцахад, 69.6 хувь буюу 1,793,172.5 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд байршиж байгаа бөгөөд үүнээс бондын эх үүсвэрийн үлдэгдэл хадгаламжид 1,567,408.0 сая төгрөг, гадаад валютаарх үлдэгдэл 97.7 сая төгрөг тус тус байна.

Арилжааны банкин дахь харилцах данс 52,959.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ОНӨААТҮГ, ХХК-иуд шинээр байгуулагдаж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл 225,764.5 сая төгрөг байгаагаас 225,727.9 сая төгрөг буюу 99.9 хувь нь ОНӨААТҮГ-уудад, 0.1 хувь буюу 36.6 сая төгрөг нь НЗДТГ болон Нийслэлийн төсвийн орлогын үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө 291,183.3 сая төгрөгөөр буурсан нь 2024 онд Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоолын дагуу бүрдүүлсэн 298,271.2 сая төгрөгийн үнэт цаасны эх үүсвэр Сангийн яамны харилцах дансанд байршиж байсныг замд яваа мөнгөн хөрөнгөөр тайлагнан 2025 оны 01 дүгээр сард Төрийн сангийн ерөнхий орлогын дансанд хүлээж авч, НИТХ-ын 2024 оны 24/33 тогтоолын дагуу батарей хураагуурын төслийг санхүүжүүлсэнтэй холбоотой буурсан байна.

Хадгаламж дансны үлдэгдэл 103,725.3 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 201, 264, 265 дугаар тогтоолын дагуу бүрдүүлсэн бондын эх үүсвэрийг хадгаламж дансанд байршуулж, тайланд онд “Сэлбэ дэд төв” төслийн санхүүжилтэд зарцуулсантай холбоотой байна.

***Хүснэгт №4. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл ТТЗ бүрээр:***

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Сүхбаатар дүүрэг | 83,874.1 | 62,828.6 | (21,045.5) | 2.4% |
| Баянгол дүүрэг | 34,332.9 | 16,658.8 | (17,674.0) | 0.6% |
| Баянзүрх дүүрэг | 18,315.3 | 40,939.2 | 22,623.9 | 1.6% |
| Чингэлтэй дүүрэг | 35,203.8 | 51,694.4 | 16,490.6 | 2.0% |
| Хан-Уул дүүрэг | 57,672.0 | 61,650.6 | 3,978.6 | 2.4% |
| Сонгинохайрхан дүүрэг | 32,457.6 | 20,558.0 | (11,899.7) | 0.8% |
| Налайх дүүрэг | 7,486.0 | 7,873.5 | 387.5 | 0.3% |
| Багануур дүүрэг | 9,248.0 | 9,831.3 | 583.3 | 0.4% |
| Багахангай дүүрэг | 2,523.9 | 2,758.2 | 234.2 | 0.1% |
| **Дүүрэг дүн** | **281,113.7** | **274,792.6** | **(6,321.1)** | **10.5%** |
| Нийслэлийн харьяа байгууллага | 2,968,223.7 | 2,329,889.4 | (638,334.4) | 89.5% |
| **Нийт дүн** | **3,249,337.4** | **2,604,681.9** | **(644,655.5)** | **100.0%** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад дүүргүүдийн мөнгөн хөрөнгө оны эхний үлдэгдэл 281,113.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 274,792.6 сая төгрөг болж 6,321.1 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд, 2024-2025 он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлсэн болон төсвийн орлогын төлөвлөгөөний тасалдал голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Нийслэлийн харьяа байгууллагуудын мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,329,889.4 сая төгрөг болж, 638,334.4 сая төгрөгийн өөрчлөлтөд дараах байгууллагууд голлох нөлөөллийг үзүүлсэн байна. Үүнд:

- Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 19,030.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд усны үнэ тариф нэмэгдээгүй тул өссөн зардлуудаа өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлсэн;
- Улаанбаатар хотын нэгдсэн төслийн нэгжийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 38,055.5 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор барьцаа хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын санхүүжилт байршуулснаас тайлант онд 31,244.1 сая төгрөгийг зарцуулж, 7,220.9 сая төгрөгийг Сангийн яаманд буцаан төвлөрүүлсэн;
- Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн өөрийн орлогын төлөвлөгөө тайлант онд 9,444.3 сая төгрөгөөр давж хөрөнгийн зардал 9,114.0 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 18,558.3 сая төгрөгөөр өссөн байна.
- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1732 дугаар захирамжаар Нийслэл дэх Төрийн албан хаагчдыг орон сууцаар дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжсэн, НОСК 1-5 ТЗК ХХК-н авлага төвлөрүүлэх ажлын хэсэг байгуулан 3 сараас дээш авлагын үлдэгдэлтэй харилцагчдын авлагыг барагдуулан ажилласантай холбоотой Нийслэлийн орон сууцны корпорацын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 18,290.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*

*Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой нийт 13,173.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, зарим материаллаг дүнтэй зөрчлийг дурдвал:*
*Нэг. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой зөрчлүүд:*

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 2,252.4 сая төгрөгийн ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан, төсөвт байгууллагын жижиг мөнгөн сан ажиллуулах журам хүчингүй болсныг хэрэгжүүлж ажиллаагүй. *(Төсвийн төвлөрүүлэн захирагч: БЗД-ийн ЗДТГ 104.3, Соёлын ордон 42.0, НҮ-ний зардал 49.8, БГД-ийн ИТХ 41.2, ЗДТГ 69.5, СУЁХ-ийн ордон 92.1, БГЦХ ОНӨААТҮГ10.9, БГШӨ ОНӨААТҮГ 164,4, Тохижилт үйлчилгээ 30.0, НД-ийн ЗДТГ 38.9, ИТХ 78,2, Хангамжийн төв ОНӨААТҮГ 12, Чандмань Налайх ОНӨААТҮГ 45.9,СХД-ийн 32.1, Нийтийн эзэмшлийн зам талбайн зардал 27.6, НД-ийн ТКХТ ОНӨТҮГ 114.7, СБД-ийн Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ 59.02, Хан-Уул агро ОНӨААТҮГ 34.5, ЧД-ийн ЗД 11.02, ХОББ-ыг дэмжих төв 16.9, БНД Усан спорт боулинг төв 30.1, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч: Төсвийн шууд захирагч-(НАГ 19.6, НАЖГ 11.7, НӨХГ 11.0, Зорчигч тээвэр дөрөв ОНӨААҮГ 34.4, Зорчигч тээвэр гурав ОНӨААҮГ 12.8, АТХБХТөв 43.3, Нийслэлийн өмчит УБХОМ ҮЦК 13.3, Хот төлөвлөлт судалгааны институт 20.7, ЖДҮДТ 28.8, УБ түншлэл 46.8, Хот Тохижилтын газар 36.5,ТХҮТ ОНӨААТҮГ 19.5 сая төгрөг гм)*
- Гадаад томилолтыг урьдчилгаа дансаар бүртгээгүй, мөнгөн урьдчилгааны тайлан хийгээгүй, томилолтын удирдамж, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 495.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хийж, данс бүртгэлд тусгасан байна.*(БЗД-н ЗДТГ 40.2, БХД-ийн ЗДТГ 29.2,ЧД ХААА 4.0, ХУД ЗДТГ 193.0, ХУД ЗДТГ 7.8, ХУД ИТХ 115.9, ХУД Дотоод аудит 5.8, ХУД Соёлын ордон 2.0, ХУД ЖДҮДТ 9.9, СХД ЗДТГ 87.9 сая төгрөг)*

- Олон талт арга хэмжээ зохион байгуулах ажлын зардлын төсөвт их хэмжээний хоол, цайны зардал 116.0 сая төгрөгөөр баталж, зарцуулж байгаа нь үрэлгэн зардал гаргасан, гүйцэтгэл, зарцуулалтын тайлан тодорхой бус байна. *(БЗД ЗДТГ 116.0 сая төгрөг)*
- Сургалт зохион байгуулсан боловч сургалтын хөтөлбөр, ирцийн бүртгэл, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж бүртгэсэн. *(ЧД ЗДТГ 222.1 сая төгрөг)*
- Гүйцэтгэлийн үр дүнг тооцоогүй ажил гүйлгээг бүртгэсэн. *(ХУД Эко хотын тээвэр ОНӨААТҮГ 206.3 сая төгрөг)*
- Бараа ажил үйлчилгээнд зарцуулсан ажил гүйлгээний гүйцэтгэлийн анхан шатны баримт хангалтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. *(ХУД ИТХ 271.3 сая төгрөг)*
- Жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн түрээсийн төлбөр, сургалтын зардал гаргасан нь гэрээ дүгнэсэн актгүй нотлох баримт дутуу байна. *(СХД ЖДҮДТ 116.2 сая төгрөг)*
- Олон улсын уралдаанд шалгарсан оролцогчдын шагналын гүйлгээний шилжүүлсэн баримт нотлогдохгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг данс бүртгэлд бүртгэсэн. *(Хүннү хотын захирагчийн ажлын алба 1,550.4 сая төгрөг)*
- Анхан шатны баримтын бүрдэл, ажлын тайлан дутуу ажил гүйлгээг данс бүртгэлд бүртгэсэн. *(Нийслэлийн ЗДТГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Нийслэлийн салбар зөвлөл 436.0 сая)*

*Хоёр: Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой зөрчлүүд:*

- 2025 онд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг тухайн хүний тэтгэвэрт гарсан, ажлаас чөлөөлсөн тушаал гаргаагүй, тэтгэвэр тогтоолтын хуудас болон холбогдох нотлох баримтгүйгээр гүйлгээ гаргасан. *(УБ театр 36.06 сая төгрөг)*

- Эдийн засгийн ангилал зөрчиж ажил гүйлгээ хийсэн, гэрээнд заасан ажил гүйлгээний үүргийг бүрэн хангуулаагүй, төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүйгээр 880.7 сая төгрөгийг зарцуулсан байна. *(БЗД-ийн ЗДТГ 10.56, ИТХ 13.81, ЖДДТ 6.0, БГД-ийн ИТХ 46.9, БГД-ийн ЗДТГ 111.02, Захиалагчийн алба ОНӨААТҮГ 50.6, Гэрэлтүүлэг тохижилт 115.7, НД-ийн ЗДТГ 3.7, НД-ийн ИТХ 5.2, НД-ийн ДАА 2.5, НД-ийн ХААА 2.2, Багахангай тохижилт 22.2, ЧД-ийн Хөрөнгө оруулалт 5.34, ЧД-ийн ЗДТГ 11.28, ЧД-ийн Теле камерын хяналтын дэд төв ОНӨТҮГ 68.4, ЧД-ийн Соёлын төв 51.8, ЧД-ийн ЖДҮДТ 5.3, СБД-ийн ИТХ 88.9, ХУД-ийн тохижилт үйлчилгээний төв 25.5, Хан-Уул Агро ОНӨААТҮГ 7.83, БНД-ийн Багануур тохижилт ОНӨААТҮГ 42.2, ИТХ 7.7, СХД-ийн ИТХ 27.8, СХД-ийн Теле камерын хяналтын дэд төв ОНӨТҮГ 56.4 сая төгрөг)*
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд заасан шууд худалдан авалт хийх төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 147.9 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн. *(БЗД Эко тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ )*
- Улсын төсвөөс санхүүждэг дүүргийн татвар, боловсролын хэлтсүүдийн үндсэн үйл ажиллагаанд нийт 385.0 сая төгрөгийн санхүүжилт дэмжлэг олгосон зэрэг нь төлөвлөлт зохион байгуулалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна. *(БЗД ЗДТГ)*
- Хөрөнгө оруулалтаар дүүргийн бүх цэцэрлэгүүд 159.6 сая төгрөгийн 6000 ширхэг хавтас авч, өгсөн нь төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үрэлгэн зарцуулсан байна. *(БЗД ЗДТГ)*
- Дүүргийн нийтийн эзэмшлийн талбайн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд 139.8 сая төгрөг, компьютер, түүний дагалдах хэрэгслийг худалдан авахад 59.5 сая төгрөг зарцуулахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж шууд гэрээ байгуулсан байна. *(БГД тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ)*
- Бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн төлбөрийг аж ахуйн нэгжийн албан ёсны дансаар бус хувь хүний дансанд 254.2 сая төгрөг шилжүүлсэн. *(БГД ЗДТГ)*
- Ахмадуудыг сувилалд амраах, сургалт зохион байгуулахад төсвөөс 95.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. *(БГД ЗДТГ)*

- Тусдаа төсөвтэй улсын төсвийн байгууллагад авто тээврийн хэрэгсэл худалдан авахад 310.0 сая төгрөг зарцуулсан. *(БГД хөрөнгө оруулалт)*
- Дүүргийн хөрөнгө оруулалтаар зардлаар Татвар, эрүүл мэндийн төв, замын цагдаа, сургууль зэрэг улсын төсвийн байгууллагад хөрөнгө бэлтгэсэн.*(ЧД ЗДТГ 852.2 сая төгрөг гм)*
- Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагын ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. *(СБД-ийн ЗДТГ 172.3 сая төгрөг гм)*
- Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримтлахгүйгээр бараа, материал шууд худалдан авсан байна. *(309.8 сая төгрөг СБ-ийн ЗДТГ гм)*
- Эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан.*(СБ ЗДТГ 234.7 сая төгрөг гм)*
- Төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй. *(Хан-Уул эко хотын тээвэр ОНӨААТҮГ 135.0 сая төгрөг гм)*
- Нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн бараа, ажил, үйлчилгээнд шууд гэрээ байгуулсан. *(154.0 сая төгрөг ХУД ЗДТГ гм)*
- Нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн бараа, ажил, үйлчилгээнд шууд гэрээ байгуулсан байна.*(ХУД ИТХ 285.8 сая төгрөг гм)*
- Төсвийн хөрөнгөөр ижил нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа 188.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан, холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. *(БНД ЗДТГ)*
- СХД-ийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 48 дугаар тогтоолоор Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 14 төсөл, арга хэмжээний 264.3 сая төгрөгийг тогтоол зөрчин орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас гаргасан.*(СХД ОНХС)*
- ОНХ сангийн данснаас зориулалт бус худалдан авалт хийсэн.*(СХД ОНХС 524.3 сая төгрөг гм)*

## 4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 1,869.1 сая төгрөг болж, өмнөх оноос 580.9 сая төгрөгөөр буурсан байна.

***Хүснэгт №5 Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны ангилал, байгууллагын төрлөөр***

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦХ ХХК | 2,450.0 | 1,869.1 | (580.9) | 100 |
| **Дүн** | **2,450.0** | **1,869.1** | **(580.9)** | **100** |
| ***Үүнээс, байгууллагын төрлөөр*** | | | | |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 2,450.0 | 1,869.1 | (580.9) | 100 |
| **Дүн** | **2,450.0** | **1,869.1** | **(580.9)** | **100** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны өөрчлөлт нь Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК ХХК нь НГБДС, НХС, НЭУС гэсэн 3 сангийн 9 нэр төрлийн 2,450 ширхэг бондоос тайлант онд 2,174 ширхгийг худалдан авч, 8,605 ширхэг бондын хугацаа дууссан тул эргэн төлөлтийг хийснээс шалтгаалан 580.9 сая төгрөгөөр буурсан байна.

## 4.3 АВЛАГА

Авлага дансны үлдэгдэл 222,580.7 сая төгрөг болж, өмнөх оноос 41,987.9 сая төгрөгөөр буурсан байна.

***Хүснэгт №6 Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр*** */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 551.8 | 669.7 | 117.9 | 0.3 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 15,160.0 | 19,398.7 | 4,238.7 | 8.7 |
| Татаас, санхүүжилтийн авлага | - | 2,687.6 | 2,687.6 | 1.2 |
| Зээлийн хүүгийн авлага | 11,644.6 | 6,100.8 | (5,543.8) | 2.7 |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 24,846.8 | 29,876.0 | 5,029.2 | 13.4 |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 9,918.9 | 10,477.6 | 558.7 | 4.7 |
| Бусад авлага | 201,995.6 | 153,079.4 | (48,916.2) | 68.8 |
| Зээлийн авлага | 450.9 | 290.9 | (160.0) | 0.1 |
| Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 290.9 | 290.9 | - | 0.1 |
| Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага | 160.0 | - | (160.0) | - |
| **Дүн** | **264,568.6** | **222,580.** | **(41,987.9)** | **100.0** |
| ***Үүнээс, байгууллагын төрлөөр*** | | | | |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 108,150.2 | 94,998.9 | (13,151.3) | 42.7 |
| Төрийн сан | 11,882.3 | 11,560.3 | (322.0) | 5.2 |
| Төсөвт байгууллага | 117,682.1 | 105,621. | (12,060.5) | 47.5 |
| Төсөл/Сан | 26,854.0 | 10,399.9 | (16,454.1) | 4.7 |
| **Дүн** | **264,568.6** | **222,580.7** | **(41,987.9)** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны нийт үлдэгдлийн 68.8 хувийг бусад авлага, 13.4 хувийг дансны авлага, 8.7 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага, 4.7 хувийг татвар, НДШ-ийн авлага, 2.7 хувийг зээлийн хүүгийн авлага, 1.2 хувийг татаас, санхүүжилтийн авлага 0.3 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага, 0.1 хувийг зээлийн авлага тус тус эзэлж байна.
Авлага дансны үлдэгдэл буурахад бусад авлага 48,916.2 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 5,543.8 сая төгрөг, зээлийн авлага 160.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна. Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 2.8 хувьд буюу 4,637.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.
Авлага дансны үлдэгдлийн 39.4 хувь буюу 87,733.4 сая төгрөг нь Нийслэлийн Тээврийн бодлогын газрын санхүүгийн тайланд тусгагдсан бөгөөд авлага өмнөх оноос 12,779.9 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Нийтийн тээврийн автобус” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн нэг бүр нь 275.9 сая төгрөгийн 600 ширхэг нийт 165,589.9 сая төгрөгийн автобусыг “Нийтийн тээврийг төлбөртэй ашиглуулах” гэрээний дагуу төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглуулж, гэрээний хугацаа дуусгавар болоход өмчлүүлэх гэрээ байгуулан авлага үүссэн, авлагаас машин цагийн элэгдлийн зардлыг тооцож авлага барагдуулсантай холбоотой байна.

УБЗЗАГ ОНӨААТҮГ-ын авлага өмнөх оноос 27,083.3 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны автозамын гэрээт ажлын авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Авлагын дансанд Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны А/1630 захирамжийн дагуу Нийтийн тээврийн парк шинэчлэлийн санг Нийтийн тээврийг хөгжүүлэх сантай нэгтгэсэнтэй холбоотой улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийслэлд шилжин ирсэн 400 ширхэг автобусны 26,854.0 сая төгрөгийн авлагыг шилжүүлэн бүртгэсэн хөдөлгөөн хийгдсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага данстай холбоотой өгсөн дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн, ажил олгогчийн буруутай шийдвэрийн улмаас ажлаас халагдсан албан хаагчдад олгосон нийт 696.0 сая төгрөгийн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.
- Авлага дансанд 4-өөс дээш жилийн насжилттай 43,350.5 сая төгрөгийн авлагууд бүртгэлтэй байгаа нь нийт авлагын 19.5 хувийг эзэлж байна. Тухайлбал, Нийтийн тээврийг хөгжүүлэх сан 26,854.0 сая төгрөг (*2009 онд үүссэн Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн сангаас нийтийн тээврийн компаниудад эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон*);
- НЖДҮҮДТ НӨҮГ 9,992.1 сая төгрөг *(2019 онд үүсэн Капитал банкнаас авах авлага 3,711.6 сая төгрөг, 2022 онд Нийслэлийн Хөдөлмөр халамжийн газраас шилжиж ирсэн Хадгаламж зээлийн хоршоодод 2014-2016 онд олгосон зээлийн авлага 6,280.5 сая төгрөг)*;

Авлагыг барагдуулах арга хэмжээг аваагүйгээс найдваргүй авлага нэмэгдэж цаашид төлөгдөх магадлал буурч төр хохирох, эзэн холбогдогч тодорхойгүй болох, хөөн хэлэлцэх хугацаа дуусах, санхүүгийн тайланд хөрөнгө хийсвэрээр өсөх, алдагдал нэмэгдэх зэрэг эрсдэлтэй байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*
*Авлагын данстай холбоотой нийт 5,343.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, зарим материаллаг дүнтэй зөрчлийг дурдвал:*

- Санхүүгийн тайланд тусгагдсан 1,670.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. *(ОУХЛТ ХК 628.0 сая төгрөг, Нийтийн тээврийг хөгжүүлэх сан 589.6 сая төгрөг, ТЦХ ОНӨААТҮГ 87.7 сая төгрөг, НХОГ НӨААТҮГ 70.9 сая төгрөг, УБЗЗАГ ОНӨААТҮГ 68.2 сая төгрөг, УСУГ ОНӨААТҮГ 66.7 сая төгрөг, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ 32.3 сая төгрөг, Налайх шуурхай удирдлага, хяналт, мэдээллийн төв ОНӨААТҮГ 31.9 сая төгрөг, УБОС ХХК 13.7 сая төгрөг, Асгат хүнс ОНӨААТҮГ 12.7 сая төгрөг, ХУД-ийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ 12.3 сая төгрөг, НД-ийн ИТХ 11.5 сая төгрөг, Чандмань Налайх ОНӨААТҮГ 11.0 сая төгрөг г.м);*
- Хугацаа хэтэрсэн 1,452.5 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. *(ОСНААУГ ОНӨААТҮГ 483.9 сая төгрөг, БЗД-ийн ЗДТГ 406.3 сая төгрөг, НОСК ХК 374.6 сая төгрөг, НЗАА 160.3 сая төгрөг, ННҮГ 14.2 сая төгрөг, БЗД-ийн ЖДҮДТ 13.2 сая төгрөг);*
- Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант онд НДШ, ХХОАТ, хувь хүмүүсээс авах 24.1 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна. *(БНД-ийн ЗДТГ 14.0 сая төгрөг г.м);*
- Санхүүгийн тайланд 89.4 сая төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүй, ангилал зөрүүтэй бүртгэж тайлагнасан байна. *(НБОГ 50.5 сая төгрөг, Монголын хүүхдийн ордон 18.5 сая төгрөг г.м);*
- Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын авлагын дансанд бүртгэлтэй 5 харилцагчтай холбоотой 2,287.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

## 4.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны үлдэгдэл 95,674.1 сая төгрөг болж, өмнөх оноос 28,276.7 сая төгрөгөөр өссөн байна.

***ХүснэгтNº7. Урьдчилгаа дансны ангилал, байгууллагын төрлөөр*** */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дундаж эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 54,381.0 | 68,592.2 | 14,211.2 | 71.7 |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 809.0 | 20,279.2 | 19,470.2 | 21.2 |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 12,037.7 | 6,041.6 | (5,996.1) | 6.3 |
| Цалингийн урьдчилгаа | 8.0 | 736.5 | 728.5 | 0.8 |
| Томилолтын урьдчилгаа | 161.7 | 24.6 | (137.2) | - |
| **Дүн** | **67,397.4** | **95,674.1** | **28,276.8** | **100.0** |
| ***Үнээс, байгууллагын төрлөөр*** | | | | |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 14,637.7 | 36,251.4 | 21,613.7 | 37.9 |
| Төрийн сан | - | - | - | - |
| Төсөвт байгууллага | 52,485.2 | 59,422.3 | 6,937.1 | 62.1 |
| Төсөл/Сан | 274.5 | 0.4 | (274.1) | - |
| **Дүн** | **67,397.4** | **95,674.4** | **28,276.8** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 71.7 хувийг урьдчилж гарсан зардал, 21.2 хувийг бараа материал бэлтгэх урьдчилгаа, 6.3 хувийг үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа, 0.8 хувийг цалингийн урьдчилгаа тус тус эзэлж байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл өсөхөд бараа материал бэлтгэх урьдчилгаа 19,470.2 сая төгрөг, урьдчилж гарсан зардал 14,211.2 сая төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Санхүүгийн тайланд тусгагдсан урьдчилгааны 62.1 хувь буюу 6,937.1 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын урьдчилгаа, 37.9 хувь буюу 36,251.4 сая төгрөгийг ОНӨҮГ-ууд тус тус эзэлж байна.

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын урьдчилгаа данс 18,010.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2025 оны он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалт, их болон урсгал засварын ажлууд бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1518 дугаар захирамжийн дагуу Бохир усны Туул-21 төслийн тендерийн баталгаанд 98.4 хувь буюу 17,716.7 сая төгрөгийг байршуулсантай холбоотой байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн хот тохижилтын зардлаас шинэ замын ажлын 13,150.5 сая төгрөгийн гэрээ байгуулж ажлын урьдчилгаанд 12,082.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь урьдчилж гарсан зардал данс өмнөх оноос өсөхөд голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/496 дугаар захирамжаар “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-т бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж, сайжруулсан түлшний хяналтын хэлтсийг өөрчлөн зохион байгуулж, “Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-ыг шинэчлэн байгуулснаар тайланд онд 1,820.6 сая төгрөгийн хийн түлшний төлбөр хуримтлуулж бүртгэсэн байна.

Урьдчилгаа дансанд он дамжсан, насжилт өндөртэй дараах урьдчилгаа хаагдаагүй байна. Үүнд:

- Улаанбаатар спорт менежмент ХК 2,434.4 сая төгрөг; *(2020 оны гэрээт ажлын урьдчилгаа),*
- ОУХЛТ ХК-ийн 248.5 сая *төгрөг;* *(2015 оны зураг төслийн ажлын урьдчилгаа);*

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*

*Урьдчилгаа данстай холбоотой нийт 746.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, зарим материаллаг дүнтэй зөрчлийг дурдвал:*

- *Санхүүгийн тайланд тусгагдсан 61.8 сая төгрөгийн урьдчилгаа дансны үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. (Нийслэлийн баруун бүсийн зам*

*засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ 47.3 сая төгрөг, Эрдэнэс баянбогд ХХК 14.5 сая төгрөг);*

- *Санхүүгийн тайланд 315.7 сая төгрөгийг он дамжин хийгдсэн ажлын урьдчилж төлсөн зардлыг тайлант оны зардлаар тайлагнасан байна. (НД-ийн Соёлын ордон 277.9 сая төгрөг, ХУД-ийн Худалдан авах ажиллагааны алба 19.1 сая төгрөг, НД-ийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв 18.7 сая төгрөг);*
- *Гадаад албан томилолтын урьдчилгаа авагчийн гаргасан гүйцэтгэл, олгосон урьдчилгаар холбогдох анхан шатны баримттай харьцуулан 349.1 сая төгрөгийн мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй байна. (ХУД-ийн ЗДТГ 193.0 сая төгрөг, ХУД-ийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал 115.9 сая төгрөг, БЗД-ийн ЗДТГ 40.2 сая төгрөг);*

## 4.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны үлдэгдэл 128,165.4 сая төгрөг болж, өмнөх оноос 40,826.8 сая төгрөгөөр өссөн байна.

***Хүснэгт №8. Бараа материал данс, байгууллагын төрлөөр*** /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+) Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Түүхий эд материал | **5,696.4** | **2,393.9** | **(3,302.5)** | **1.9** |
| Тусгай зориулалттай материал | 5,671.6 | 2,353.2 | (3,318.4) | 1.8 |
| Эм боох материал | 24.8 | 40.7 | 15.9 | 0.03 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 9,242.7 | 10,953.4 | 1,710.7 | 8.6 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 13,114.2 | 14,523.4 | 1,409.2 | 11.3 |
| Хангамжийн материал | **58,822.0** | **100,091.0** | **41,269.0** | **78.1** |
| Бичиг хэргийн материал | 1,060.3 | 921.2 | (139.1) | 0.7 |
| Аж ахуйн материал | 25,438.9 | 28,241.1 | 2,802.2 | 22.0 |
| Сэлбэг хэрэгсэл | 7,235.9 | 11,413.9 | 4,178.0 | 9.0 |
| Түлш шатах тослох материал | 1,924.0 | 2,066.6 | 142.6 | 1.6 |
| Барилгын засварын материал | 1,097.3 | 984.7 | (112.6) | 0.8 |
| Хүнсний материал | 190.3 | 152.3 | (38.0) | 0.1 |
| Бусад хангамжийн материал | 21,875.3 | 56,311.2 | 34,435.9 | 43.9 |
| Биологийн хөрөнгө | 452.0 | 162.4 | (289.6) | 0.1 |
| Мал амьтад | 11.3 | 41.3 | 30.0 | 0.03 |
| **Дүн** | **87,338.6** | **128,165.4** | **40,826.8** | **100.0** |
| ***Үүнээс, байгууллагын төрлөөр харуулбал:*** | | | | |
| ОНӨҮГ | 60,348.7 | 68,878.9 | 8,530.2 | 53.7 |
| Төсөвт байгууллага | 26,720.9 | 59,162.1 | 32,441.2 | 46.2 |
| Төсөл/сан | 269.0 | 124.4 | (144.6) | 0.1 |
| **Дүн** | **87,338.6** | **128,165.4** | **40,826.8** | **100** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал дансны 78.1 хувь буюу 100,091.0 сая төгрөгийг хангамжийн материал, 11.3 хувь буюу 14,523.4 сая төгрөгийг бэлэн бүтээгдэхүүн, 8.6 хувь буюу 10,953.4 сая төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэл, 1.9 хувь буюу 2,393.9 сая төгрөгийг түүхий эд материал, 0.1 хувь буюу 162.4 сая төгрөгийг биологийн хөрөнгө, 0.03 хувь буюу 41.3 сая төгрөгийг мал амьтад тус тус эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,826.8 сая төгрөг буюу 31.8 хувиар өсөхөд СХД-ийн ТТЗ 19,962.1 сая төгрөг, Хотын шуудын байгууллагууд 8,519.1 сая төгрөг, БЗД-ийн ТТЗ 6,392.7 сая төгрөг, СБД-ийн ТТЗ 2,428.6 сая төгрөг, БГД-ийн ТТЗ 1,328.8 сая төгрөг, ЧД-ийн ТТЗ 1,052.9 сая төгрөг, ХУД-ийн ТТЗ 920.3 сая төгрөгөөр бараа материалын үлдэгдлийг өсгөсөн нь голлон нөлөөлсөн байна.

Хангамжийн материал дансны 41,269.0 сая төгрөгийн өсөлтөд бусад хангамжийн материал 28,294.7 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 4,600.9 сая төгрөгийн өсөлтүүд голлон

нөлөөлсөн байна. Тайлант онд СХД-ийн ЗДТГ-т НТХО-аар агаарын чанарыг сайжруулах гэр хорооллын бүсийн айл өрхөд стандартад нийцсэн давхар шаталтат зуух суурилуулж, 23,634 ширхэг 20,207.1 сая төгрөгийн өртөг бүхий зуухыг НӨХГ-ын шийдвэрийн дагуу бүртгэсэн, ГУББГ ОНӨААТҮГ нь Чингэсийн өргөн чөлөө, вокзал орчмын бороо-ны ус зайлуулах, Сэлбэ усан сангийн ажил гүйцэтгэхээр 2,741.3 сая төгрөгийн бараа материал, Зорчигч тээвэр-1 ОНӨААТҮГ нийтийн тээврийн 2 төрлийн автобусны сэлбэг тос тосолгооны материалыг 3,441.3 сая төгрөгөөр тус тус худалдаж авсан нь голлон нөлөөлсөн байна.

Түүхий эд материал дансны 3,302.5 сая төгрөгийн бууралтад Нийслэлийн цахим, хөгжил мэдээлэл технологийн газар татан буугдсантай холбоотойгоор 4,135.6 сая төгрөгийн бараа материалыг НЗДТГ, ЗХУТ ОНӨААТҮГ зэрэг байгууллагууд бусад хангамжийн материал, машин тоног төхөөрөмжийн дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй үйлдвэрлэл дансны 1,710.7 сая төгрөгийн өсөлтөд БЗД-ийн ХОББТ ОНӨААТҮГ нь 2025 онд БЗД-ийн 19 дүгээр хороонд картон цаасны үйлдвэрийн барилгын ажил, 33 дугаар хороонд баазын барилгын ажлыг тус тус эхлүүлж, 23 байршилд шинээр тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж байгаа зэрэг он дамжсан ажлуудыг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Бэлэн бүтээгдэхүүн дансны 1,409.2 сая төгрөгийн өсөлтөд УБСК ХХК нь автобусны карт уншуулах төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл болон картын нэмэлт захиалга, ҮЦХ ОНӨААТҮГ нь 1,471.8 сая төгрөгийн бут сөөгийг бүртгэж авсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсөвт байгууллагын бараа материалын дансны үлдэгдэл өсөхөд СХД-ийн ТТЗ бусад хангамжийн материал 19,962.1 сая төгрөг болж өссөн, БЗД-ийн ТТЗ дуусаагүй үйлдвэрлэл, хангамжийн материал 6,392.7 сая төгрөг болж өссөн, Хотын шуудын байгууллагууд 8,519.1 сая төгрөгийн он дамжин хийгдэх болон шилжүүлэх зориулалттай хөрөнгүүдийг бэлэн бүтээгдэхүүн, бусад хангамжийн материал зэрэг дансанд бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бараа материалын дансны үлдэгдлийн өсөлтөд Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-д НИТХ-ын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/40 дугаар тогтоол, НОСК ХК-ийн захирлын тушаалын дагуу 2,846.7 сая төгрөгийн хөрөнгийг хүлээлгэн өгсөн, Зорчигч тээвэр-1 ОНӨААТҮГ нь нийтийн тээврийн 2 төрлийн автобусны сэлбэг тос тосолгооны материалыг 3,441.3 сая төгрөгөөр, ГУББГ ОНӨААТҮГ нь Чингэсийн өргөн чөлөө, вокзал орчмын борооны ус зайлуулах, Сэлбэ усан сангийн ажил гүйцэтгэхээр 2,741.3 сая төгрөгийн материал худалдан авсан боловч тендерийн хугацаа хойшлогдсон, зураг төсөл өөрчлөгдсөн нь голлон нөлөөлсөн байна.

Төсөл сангийн бараа материалын үлдэгдлийн бууралтад Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж тайлант онд 182.6 сая төгрөгийн материал худалдан авч, 307.2 сая төгрөгийг зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Бараа материалын данстай холбоотой нийт 4,737.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, зарим материаллаг дүнтэй зөрчлийг дурдвал:*

- Бараа материалыг бөөн дүнгээр орлого авсан, зарлага болгосон, тоо хэмжээ, нэгжийн үнэ буруу бүртгэсэн 143.4 сая төгрөг *(БГД-ийн ИТХ 59.5 сая, ЧД-ийн ЗДТГ 44.5 сая, БЗД-ийн ЗДТГ 15.9 сая, НХХААГ 13.5 сая, ТХҮТ 10.0 сая төгрөг г.м)*
- Бараа материалын дансанд хөрөнгийн шинж чанартай материал бүртгэсэн, материалын ангилал буруу бүртгэсэн 130.0 сая төгрөг *(НД-ийн ИТХ 50.0 сая, ТКХТ 48.5 сая, ХУД-ийн Эко ахмадын сувилал 19.6 сая, ХУД-ийн Хан эко тээвэр 11.9 сая төгрөг г.м )*
- Бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүй, үр дүнг тайлагнаагүй 1,632.3 сая төгрөг *(НЗДТГ)*
- Их хэмжээний материалын үлдэгдэлтэй, нэмж орлого авсан, ашиглалтгүй материалын үлдэгдэлтэй байна. 292.1 сая төгрөг *(АБ 113.7 сая, ЦБА 63.1 сая, ХҮА 45.4 сая, ЗУХА 44.2 сая, УЦБА 25.7 сая төгрөг г.м)*
- Бараа материалыг орлого аваагүй шууд зардлаар бүртгэсэн 895.9 сая төгрөг *(Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр 344.3 сая, НЗДТ 280.1 сая, НХТГ 102.5 сая, БГД-ийн ИТХ 41.6 сая, УБСК 35.3 сая, НАТХБХ Т 33.7 сая, НД-ийн ИТХ 23.3 сая,ЧД-ийн ЗДТГ 22.5 сая, ДТЦС 12.6 сая төгрөг г.м)*
- Анхан шатны материалын бүрдэл дутуу,материал зарлагдсан, тогтоосон норм нормативыг зөрчсөн 1,108.5 сая төгрөг *(УХА 232.9 сая, ШАУЗА 143.2 сая, ХИХУГ 135.5 сая, Зорчигч тээвэр гурав 74.4 сая, БГД-ийн БГТ 67.4 сая, ЗХУТ 67.3 сая,СХД-ийн ЗДТГ 66.4 сая, ҮЦХ 46.6 сая, СХД-ийн ИТХ 46.5 сая, НЖДҮҮДТ 34.2 сая, НАТХБХТ 31.7 сая, Зорчигч тээвэр дөрөв 25.2 сая, НХЗСХТЦ 17.4 сая, Зорчигч тээвэр нэг 16.9 сая,НХХААГ 13.6 сая, НИТХ 12.0 сая, БЗД-ийн ИТХ 11,8 сая, ОСБГ 11.5 сая,БЗД-ийн ИТХ 11.8 сая, ХУД-ийн эко ахмадын сувилал 10.9 сая, ОСНААУГ 10.8 сая Зорчигч тээвэр хоёр 10.5 сая ЗАА 10.0 сая төгрөг г.м)*
- Холбогдох тушаал шийдвэр гараагүй байхад бараа материал акталсан, устгалын акт үйлдээгүй 197,9 сая төгрөг *(УСУГ 184.2 сая, НЖДҮДТ 13.7 сая, төгрөг г.м)*
- Дүүргийн гэрэлтүүлэг тохижилтын зардлаас 19.7 сая төгрөгийн цахилгаан хадуур худалдан авсан болович ашиглагч байгууллагад шилжүүлээгүй данс бүртгэлд тусгаагүй байна. *(ГТҮТ)*

### 4.5.1 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 359.3 сая төгрөг болж, өмнөх оноос 770.6 сая төгрөгөөр буурсан байна.

***Хүснэгт №9. Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр*** /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Төсөвт байгууллага | 349.3 | 359.3 | 10.0 | 100.0 |
| ОНӨҮГ | 780.6 | 0.0 | (780.6) | 0.0 |
| **Дүн** | 349.3 | 359.3 | 10.0 | 100.0 |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсөвт байгууллагын нөөцийн барааны дансны үлдэгдэл 10.0 сая төгрөгөөр өссөн нь НБОГ тайлант онд 10.0 сая төгрөгийн үрийн нөөц бэлтгэсэн, Багахангай дүүрэг нь хөрөнгө оруулалтаар хийгдэх 349.3 сая төгрөгийн зураг төсвийн ажлыг нэмж бүртгэсэнтэй тус тус холбоотой байна.
ОНӨААТҮГ-ын нөөцийн бараа дансны бууралтад БГД-ийн ТТЗ (*Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ/* 575.9 сая төгрөгийн, ХУД ТТЗ */Эко хотын тээвэр ОНӨААТҮГ)* 204.6 сая төгрөгийн халтиргаа гулгаа арилгах давс, бодисыг тус тус зарцуулж, дуусcантай холбоотойгоор буурсан байна.

## 4.6. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 2,575,900.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,126,666.7 сая төгрөгөөр өссөн байна.

***Хүснэгт №10  Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр*** /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ОНӨҮГ | 648,496.0 | 1,171,705.6 | 523,209.6 | 45.5 |
| Төсөвт байгууллага | 711,070.5 | 1,305,785.6 | 594,715.1 | 50.7 |
| Төсөл сан | 89,667.3 | 98,409.3 | 8,742.0 | 3.8 |
| ***Дүн*** | ***1,449,233.8*** | ***2,575,900.5*** | ***1,126,666.7*** | ***100*** |
| ***Үүнээс, ТТЗ бүрээр харуулбал:*** | | | | |
| Орон нутгийн төсөвт байгууллага | 1,268,959.7 | 2,330,511.3 | 1,061,551.6 | 90.5 |
| Сүхбаатар дүүрэг | 61,047.1 | 87,760.9 | 26,713.8 | 3.4 |
| Баянзүрх дүүрэг | 45,682.4 | (9,570.0) | 45,682.4 | 0.4 |
| Сонгинохайрхан дүүрэг | 25,356.7 | 25,712.2 | 355.5 | 1.0 |
| Хан-Уул дүүрэг | 20,444.0 | 33,191.9 | 12,747.9 | 1.3 |
| Чингэлтэй дүүрэг | 17,588.7 | 33,473.3 | 15,884.6 | 1.3 |
| Баянгол дүүрэг | 10,095.8 | 28,277.6 | 18,181.8 | 1.1 |
| Налайх дүүрэг | - | 223.0 | 223.0 | 0.0 |
| Багахангай дүүрэг | 59.4 | 637.9 | 578.5 | 0.02 |
| ***Дүн*** | ***1,449,233.8*** | ***2,575,900.5*** | ***461,528.7*** | ***100*** |

*Эх сурвалж: НТЕЗ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл өсөхөд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.4-д заасны дагуу нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй шилжүүлэх зориулалттай дуусаагүй болон он дамжин хэрэгжих ажлуудыг бүртгэж тайлагнасан, мөн дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байсан он дамжин хийгдэх ажлуудыг шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна. (*Тухайлбал: НХОГ 856,459.8 сая төгрөг, НЗХГ 731,864.5 сая төгрөг, Сэлбэ хорин минутын хот корпораци ХХК 293,615.5 сая төгрөг, СБД, БЗД, ХУД, БГД, ЧД, СХД-ийн ОНХС, ОНХО, ХОС 224,749.8 сая* төгрөг, *Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж 97,827.2 сая төгрөг, Нийслэлийн нийтийн тээврийн газар, 98,716.1 сая төгрөг, ЗХУТ 74,879.3 сая төгрөг, Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэгж 74,820.4 сая төгрөг, НЗАА 51,151.7 сая төгрөг, ЭХҮТП 20,000.0 сая төгрөг, НЗДТГ 16,298.6 сая төгрөг, СХД-ийн ЗДТГ 14,288.4 сая төгрөг, Гэр хорооллын хөгжлийн газар 7,882.0 мянган төгрөг, НЕТГ 4,783.6 сая төгрөг, ЧД-ийн ХОББДТ 4,484.5 сая төгрөг г.м*)

## 4.7. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 300,002.6 сая төгрөг болж, өмнөх оноос 173.3 сая төгрөгөөр буурсан байна.

***Хүснэгт №11 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны ангилал, байгууллагын төрлөөр***

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 300,176.0 | 300,002.6 | (173.3) | 100 |
| **Дүн** | **300,176.0** | **300,002.6** | **(173.3)** | **100.0** |
| ***Үүнээс, байгууллагын төрлөөр*** | | | | |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 300,176.0 | 300,002.6 | (173.3) | 100.0 |
| **Дүн** | **300,176.0** | **300,002.6** | **(173.3)** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансанд оны эхэнд Нийслэлийн Орон сууцны корпорац 980.0 сая төгрөг, Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК-д 646.8 сая төгрөг, Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК ХХК-д 300,000.0 сая төгрөгийн зээл байна. Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь итгэмжлэн удирдаж буй "Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС ТЗК" ХХК-д Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжих Бөөрөлжүүт цахилгаан станцын төсөлд зориулан 300,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 300,000.0 сая төгрөгийн үнэ бүхий нэгж эрх эзэмшихээр шийдвэрлэсэн болон "Нийслэлийн гарааны бизнесийг дэмжих сан хувийн ХОС ТЗК" ХХК гарааны бизнесийг дэмжих сангийн Бичил глобус ББСБ-аас гаргасан BG бондыг эргэн төлсөнтэй холбоотойгоор 174.3 сая төгрөгөөр буурч, Улаанбаатар смарт карт ХХК нь урт хугацаат хөрөнгө оруулалт нэмж бүртгэсэнтэй холбоотойгоор 1.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

## 4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,930,347.1 сая төгрөг болж, өмнөх оноос 603,699.9 сая төгрөгөөр өссөн байна.

***Хүснэгт №12 Үндсэн хөрөнгийн дансны ангилал, байгууллагын төрөл, захирагчаар***

*/сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт, Бууралт ( ) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Дансны ангиллаар** | | | | |
| Газар | - | - | | - |
| Биет хөрөнгө | 1,879,957.0 | 2,337,089.8 | 457,132.8 | 59.5 |
| Биет бус хөрөнгө | 1,203,813.8 | 1,334,119.0 | 130,305.2 | 33.9 |
| Бусад хөрөнгө /ОНӨҮГ/ | 242,876.4 | 259,138.3 | 16,261.9 | 6.6 |
| **Дүн** | **3,326,647.2** | **3,930,347.1** | 603,699.9 | 100.0 |
| **Байгууллагын төрлөөр** | | | | |
| Төсөвт байгууллага | 1,391,467.2 | 1,374,720.1 | (16,747.1) | 35.0 |
| Төсөл/сан | 530.9 | 917.0 | 386.1 | 0.02 |
| ОНӨҮГ | 1,934,649.1 | 2,554,709.9 | 620,060.8 | 65.0 |
| **Дүн** | **3,326,647.2** | **3,930,347.1** | **603,699.9** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн 59.5 хувь буюу 2,337,089.8 сая төгрөгийг биет хөрөнгө, 33.9 хувь буюу 1,334,119.0 сая төгрөгийг биет бус хөрөнгө, 6.6 хувь буюу 259,138.3 сая төгрөгийг бусад хөрөнгө тус тус эзэлж байна.
Нийт үндсэн хөрөнгийн 65.0 хувь буюу 2,554,709.9 сая төгрөгийг ОНӨҮГ-ын хөрөнгө, 35.0 хувь буюу 1,374,720.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын хөрөнгө, 0.02 хувь буюу 386.1 сая төгрөгийг төсөл сангийн хөрөнгө тус тус эзэлж байна.

ОНӨҮГ-уудын үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн өсөлтөд шинээр байгуулагдсан орон нутгийн өмчит байгууллагуудад бэлтгэсэн хөрөнгө 78,622.2 сая төгрөг (Тодруулбал,*Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв 21,931.7 сая, УБ Орон сууцжуулалт ХХК 21,910.6 сая төгрөг, УБ Смарт карт ХХК 17,344.2 сая, Теле камерын хяналтын дэд төвүүд 8,992.1 сая төгрөг г м*), худалдаж авсан хөрөнгө 106,294.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтын ажлын 474,437.1 сая төгрөгийн хөрөнгө (*Тухайлбал, УБ хотын хөгжлийн корпорац 269,700.0 сая төгрөг, Зорчигч тээвэр хоёр 23,976.8 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэн 17,890.9 сая төгрөг, УСУГ 17,732.0 сая төгрөг, Замын хөдөлгөөний удирдлагын төв 16,772.7 сая төгрөг, Соёлын төв өргөө 14,258.7 сая төгрөг гэх мэт*) бүртгэж авсан нь голлон нөлөөлсөн байна.

Их хэмжээний өсөлттэй өөрчлөлтийг тодруулбал, Улаанбаатар хотын хөгжлийн корпорац нь тайлант онд "Багануур Батарей хуримтлуурын станцын 220/*110/35 кВ-ын дэд станцын өргөтгөл бүхий эрчим хүчний хуримтлуурын станцын барилга, байгууламж, тоног төхөөрөмж нийт 286,141.0 сая төгрөгийн хөрөнгийг нэмж бүртгэсэн, Зорчигч тээвэр-2 ОНӨААТҮГ-т Нийслэлийн ЗД-ын 2025 оны захирамж шийдвэрээр 10,836.7 сая төгрөгийн Skyworth загварын 15 тээврийн хэрэгсэл, 14,809.4 сая төгрөгийн Yutong автобус орлогод авсан зэрэг нь голлох нөлөөлсөн байна.

Төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,374,720.1 сая төгрөг болж 16,747.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 265,829.1 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдүүлж, холбогдох шийдвэрүүдээр 138,608.9 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж, 38,906.5 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хасаж, 105,060.8 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна. (*Тодруулбал, НЗДТГ 79,639.9 сая төгрөг, СХД-ийн Дэд бүтцийн хөгжлийн алба 25,294.7 сая төгрөг, БЗД-ийн ЗДТГ 16,039.2 сая төгрөг, НЗАА 9,808.2 сая төгрөг, НӨХГ 8,881.5 сая төгрөг, НТЗАБ 2,850.4 сая төгрөг, ЧД ЗДТГ 1,772.1 сая төгрөг, ХУД ЗДТГ 1,238.8 сая төгрөг, БНД ЗДТГ1,234.5 сая төгрөг, БЗД НҮГ-ууд 622.4 сая төгрөг, НҮГ 420.3 сая төгрөг, БНД УСБТөв 181.9 сая төгрөг, ҮХААГ 115.8 сая төгрөг, ҮИГ 104.6 сая төгрөг, СБД ИТХ 102.0 сая төгрөг, ХУД ИТХ 87.2 сая төгрөг, Хүүхэд хөгжлийн төв 72.5 сая төгрөг, БЗД ЖДҮДТөв 65.2 сая төгрөг, ХУБТөв 61.2 сая төгрөг, Гачуурт тосгоны ТГ 59.7 сая төгрөг, СХД ИТХ 55.3 сая төгрөг, БЗД ИТХ 46.7 сая төгрөг, СХД СО 36.9 сая төгрөг, БХД СО 36.3 сая төгрөг, БХД ЖДҮДТ 32.8 сая төгрөг, БНД ЖДҮДТ 27.2 сая төгрөг, СХД УССТ 26.8 сая төгрөг, НД ИТХ 23.8 сая төгрөг, ХНӨ 18.6 сая төгрөг, БЗД ДАА 14.3 сая төгрөг, НД ХААА 13.3 сая төгрөг, БНД СО 10.1 сая төгрөг г м* ).

Төсөл сан, зардлын үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл цэвэр дүнгээрээ 917.0 сая төгрөг болж 386.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 785.2 сая төгрөгийн хөрөнгө орлогоор бүртгэсэн нь нөлөөлсөн байна. (*Тухайлбал, Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж хөрөнгө 455.8 сая төгрөг, ГХУСАЗЗ-ийн Нийслэл дэх салбар зөвлөл 1,784.9 сая төгрөг*).

### 4.8.1. Үндсэн хөрөнгийн дансны бүтэц

Үндсэн хөрөнгийн дансны 603,699.9 сая төгрөгийн өсөлтөд барилга, байгууламж, орон сууц 28,647.9 сая төгрөг, авто-тээврийн хэрэгсэл 28,482.2 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 396,746.9 сая төгрөг, тавилга, аж ахуйн эд хогшил 8,931.1 сая төгрөг, Зам, гүүрний байгууламж 42,544.3 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 142,859.1 сая төгрөг, биет бус хөрөнгө 130,305.2 сая төгрөгөөр, бусад хөрөнгө 16,261.9 сая төгрөгийн тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Харин хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө 526.3 сая төгрөгөөр буурчээ.

***Хүснэгт №13. Үндсэн хөрөнгийн дансны ангиллаар*** /*сая төгрөг*/

| Данс | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт, Бууралт | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| **39100** | Газар | - | - | | - |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,879,957.0** | **2,337,089.8** | **357,132.8** | **58.4** |
| **39201** | Барилга, байгууламж, орон сууц | 1,091,059.9 | 1,119,707.8 | 28,647.9 | 29.2 |
| **39202** | Хуримтлагдсан элэгдэл | (331,292.4) | (351,985.6) | (20,693.2) | (9.2) |
| **39203** | Авто-тээврийн хэрэгсэл | 364,177.0 | 392,659.2 | 28,482.2 | 10.0 |
| **39204** | Хуримтлагдсан элэгдэл | (98,810.0) | (118,470.2) | (19,660.2) | (3.1) |
| **39205** | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 367,951.3 | 764,698.2 | 396,746.9 | 20.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **39206** | Хуримтлагдсан элэгдэл | (243,338.5) | (294,634.5) | (51,296.0) | (7.7) |
| **39207** | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,052.7 | 46,983.8 | 8,931.1 | 1.2 |
| **39208** | Хуримтлагдсан элэгдэл | (19,968.8) | (20,365.9) | (397.1) | (0.5) |
| **39209** | Зам, гүүрийн байгууламж | 357,601.1 | 400,145.4 | 42,544.3 | 10.4 |
| **39210** | Хуримтлагдсан элэгдэл | (108,070.9) | (134,960.5) | (26,889.6) | (3.5) |
| **39211** | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 76.2 | 76.2 | - | 0.0 |
| **39212** | Хуримтлагдсан элэгдэл | (29.7) | (43.7) | (14.0) | (0.0) |
| **39213** | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 560.3 | 561.3 | 1.0 | 0.0 |
| **39214** | Бусад үндсэн хөрөнгө | 652,142.8 | 795,001.9 | 142,859.1 | 20.8 |
| **39215** | Хуримтлагдсан элэгдэл | (204,887.1) | (278,863.8) | (73,976.7) | (7.3) |
| **39216** | Дуусаагүй барилга, байгууламж | 13,343.8 | 15,152.6 | 1,808.8 | 0.4 |
| **39217** | Ном | 1,389.3 | 1,427.6 | 38.3 | 0.0 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,203,813.8** | **1,334,119.0** | **130,305.2** | **34.8** |
| **39301** | Программ хангамж | 11,422.1 | 18,559.4 | 7,137.3 | 0.5 |
| **39302** | Хуримтлагдсан элэгдэл | (6,549.6) | (7,165.8) | (616.2) | (0.2) |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | 1,223,088.2 | 1,343,896.6 | 120,808.4 | 35.1 |
| **39304** | Хуримтлагдсан элэгдэл | (24,146.9) | (21,171.2) | 2,975.7 | (0.6) |
| **39400** | **Бусад хөрөнгө /ОНӨҮГ/** | **242,876.4** | **259,138.3** | **16,261.9** | **6.8** |
| **39401** | Биологийн хөрөнгө /ОНӨҮГ/ | - | 1,543.1 | 1,543.1 | 0.0 |
| **39402** | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ОНӨҮГ/ | 5,709.1 | 5,867.0 | 157.9 | 0.2 |
| **39403** | Хойшлогдсон татварын хөрөнгө /ОНӨҮГ/ | 224.7 | 224.7 | - | 0.0 |
| **39404** | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ОНӨҮГ/ | 22,237.0 | 21,710.7 | (526.3) | 0.6 |
| **39405** | Бусад эргэлтийн бус хөрөнгө /ОНӨҮГ/ бусад | 214,705.6 | 229,792.8 | 15,087.2 | 6.0 |
| | **Дүн** | **3,326,647.2** | **3,930,347.1** | **603,699.9** | **100.0** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн 58.4 хувь буюу 2,337,088.8 сая төгрөгийг биет хөрөнгө, 34.8 хувь буюу 1,334,119.0 сая төгрөгийг биет бус хөрөнгө, 6.8 хувь буюу 259,138.3 сая төгрөгийг бусад хөрөнгө тус тус эзэлж байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 1,808.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 15,152.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. (*Тодруулбал: УБ Спорт менежмент 12,661.0 сая төгрөг, УСУГ 1,994.2 сая төгрөг, БГ Шинэ-Өргөө 218.2 сая төгрөг, НӨХГ 141.3 сая төгрөг, ОУЭЦХ 88.0 сая төгрөг, БГД Хүүхдийн Зуслан 49.9 сая төгрөг*).

## 4.8.2. Үндсэн хөрөнгийн дансны хөдөлгөөн

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 1,077,645,5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдүүлж, 283,378.4 сая төгрөгийн хөрөнгө буурснаар тайлагнасан байна.

***Хүснэгт №14. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дансны ангиллаар*** */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Биет хөрөнгө | Биет бус хөрөнгө | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл | 2,886,354.3 | 1,234,510.3 | 242,876.5 | 4,363,741.1 |
| Нэмэгдсэн | 866,443.1 | 182,635.4 | 28,567.0 | 1,077,645.5 |
| Худалдан авсан | 107,775.7 | 34,676.8 | 660.3 | 143,112.8 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хандиваар | 180,008.6 | 127,176.1 | 1,543.1 | 308,727.8 |
| Шилжүүлэн авсан | 87,822.5 | 6,380.5 | 22,137.8 | 116,340.8 |
| Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр | - | - | - | - |
| Бусад | 490,836.3 | 14,402.0 | 4,225.8 | 509,464.1 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | - | - | - | - |
| Хасагдсан | 216,383.5 | 54,689.7 | 12,305.2 | 283,378.4 |
| Худалдсан | 1,103.5 | - | - | 1,103.5 |
| Акталсан | 53,670.0 | 4,003.6 | 286.4 | 57,960.0 |
| Шилжүүлсэн | 119,042.3 | 36,861.2 | 46.5 | 155,950.0 |
| Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр | - | - | - | - |
| Бусад | 42,567.7 | 13,824.9 | 11,972.3 | 68,364.9 |
| Дахин үнэлгээний хорогдол | | | | - |
| Үндсэн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл | 3,536,413.9 | 1,362,456.0 | 259,138.3 | 5,158,008.2 |
| Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл | (1,006,397.3) | (30,696.6) | - | (1,037,093.9) |
| Өмнөх оны элэгдлийн зөрүү | (4,545.7) | (36.5) | - | (4,582.2) |
| Зардал | (292,326.1) | (9,491.7) | - | (301,817.8) |
| Элэгдлийн зардал тайлант хугацааны | (238,196.6) | (8,047.3) | - | (246,243.9) |
| Элэгдлийн зардал Бусад | (54,129.5) | (1,444.4) | | (55,573.9) |
| Дансны хасалт | 104,018.0 | 11,814.8 | - | 115,832.8 |
| Бусад | 104,018.0 | 11,814.8 | | 115,832.8 |
| Дахин үнэлгээний | - | - | - | - |
| Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл | (1,199,251.1) | (28,410.0) | - | (1,227,661.1) |
| Үлдэгдэл өртөг | 2,337,162.8 | 1,334,046.0 | 259,138.3 | 3,930,347.1 |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант хугацаанд хөрөнгийн элэгдлийн зардалд 301,817.8 сая төгрөгөөр тооцож, 115,832.8 сая төгрөгийн дансны хасалт хийгдсэн байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 659,353.5 сая төгрөг, төсөвт байгууллага 417,506.8 сая төгрөг, төсөл/сангууд 785.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 105,863.0 сая төгрөг, төсөвт байгууллага 177,515.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

***Хүснэгт №15. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн байгууллагын ангиллаар*** */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар | Төсөвт байгууллага | Төсөл/ Сангууд | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,649,863.5** | **1,713,258.0** | **619.6** | **4,363,741.1** |
| Нэмэгдсэн | **659,353.5** | **417,506.8** | **785.2** | **1,077,645.5** |
| Худалдан авсан | 106,294.4 | 36,160.0 | 658.4 | 143,112.8 |
| Хандиваар | 23,641.0 | 284,960.0 | 126.8 | 308,727.8 |
| Шилжүүлэн авсан | 46,965.8 | 69,375.0 | | 116,340.8 |
| Бусад | 482,452.3 | 27,011.8 | | 509,464.1 |
| Хасагдсан | **105,863.0** | **177,515.4** | **-** | **283,378.4** |
| Худалдсан | 3.3 | 1,100.2 | | 1,103.5 |
| Акталсан | 20,153.7 | 37,806.3 | | 57,960.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Шилжүүлсэн | 31,294.4 | 124,655.6 | | 155,950.0 |
| Бусад | 54,411.6 | 13,953.3 | | 68,364.9 |
| **Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,203,354.0** | **1,953,249.4** | **1,404.8** | **5,158,008.2** |
| **Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл** | **(532,131.0)** | **(504,804.4)** | **(158.5)** | **(1,037,093.9)** |
| Өмнөх оны элэгдлийн зөрүү | (275.4) | (4,306.8) | | (4,582.2) |
| Зардал | **(148,023.3)** | **(153,465.1)** | **(329.4)** | **(301,817.8)** |
| Элэгдлийн зардал тайлант хугацааны | (140,889.5) | (105,060.8) | (293.6) | (246,243.9) |
| Элэгдлийн зардал Бусад | (7,133.8) | (48,404.3) | (35.8) | (55,573.9) |
| Дансны хасалт | **31,785.6** | **84,047.2** | **-** | 115,832.8 |
| Бусад | 31,785.6 | 84,047.2 | | 115,832.8 |
| Дахин үнэлгээний | | | | - |
| **Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **(648,644.1)** | **(578,529.1)** | **(487.9)** | **(1,227,661.1)** |
| **Үлдэгдэл өртөг** | **2,554,709.9** | **1,374,720.3** | **916.9** | **3,930,347.1** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Хөрөнгийн элэгдлийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 148,023.3 сая төгрөг, төсөвт байгууллага 153,465.1 сая төгрөг, төсөл/сангууд 329.3 сая төгрөгөөр тооцож, 115,832.8 сая төгрөгийн дансны хасалтыг хийжээ.

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*

*Үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 4,865.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнээс материаллаг дүнтэй зарим зөрчлийг дурдвал:*

- Жилийн эцсийн тооллогын холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн хийгээгүй, тооллого комисс томилж тушаал шийдвэр гаргаагүй 1,384.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. *(Хүннү хотын ЗАА 566.8 сая төгрөг, Налайх шуурхай удирдлага, хяналт, мэдээллийн төв ОНӨААТҮГ 343.1 сая төгрөг, НД-ийн ИТХ 163.4 сая төгрөг, НБЗЗАГ ОНӨААТҮГ 136.3 сая төгрөг, БХД-ийн ЖДҮДТ 58.4 сая төгрөг, БЗД-ийн УССТ 50.3 сая төгрөг, НАГ 13.1 сая төгрөг, ЧД-ийн СО 12.4 сая төгрөг, БГД-ийн ЖДҮДТ 9.7 сая төгрөг, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ОНӨААТҮГ 9.3 сая төгрөг гм )*
- НЗД-ын 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн "Өр барагдуулах тухай" А/265 захирамжаар Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ийн 2013 оноос хойш битүүмжлэгдсэн 290.4 сая төгрөгийн бараа материал, 819.2 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгө, нийт 1,109.6 сая төгрөгийн хөрөнгийг хүлээж авсан ШШГГ, банк болон бусад ажлын хэсгийн акт зэрэг анхан шатны баримтууд байхгүй байна.
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй 674.2 сая төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах хугацааг тодорхойлж, дахин үнэлж бүртгээгүй, холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлээгүй байна. *(Үүнд, БЗД-ийн ЗДТГ 289.0 сяа төгрөг, ННҮГ 162.9 сая төгрөг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ 114.8 сая төгрөг, СБД-ийн ДАА 10.9 сая төгрөг, СБД-ийн ЖДҮДТ 49.8 сая төгрөг, СБД-ийн ХААА 2.0 сая төгрөг, УХНТНС 43.3 сая төгрөг, ЧД-ийн ЗДТГ 1.5 сая төгрөг)*
- Нийт 338.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, шилжүүлээгүй, өртгийг үнэн зөв тогтоогоогүй, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. *(үүнд, Асгат хүнс 2.6 сая төгрөг, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк ХК 30.6 сая төгрөг, БТҮ 83.3 сая төгрөг, Дулааны тавдугаар цахилгаан станц ОНӨААТҮГ 17.1 сая төгрөг, НД-ийн СО 36.7 сая төгрөг, НЖДҮҮДТ 68.9 сая төгрөг, НХААГ 5.8 сая төгрөг, НХААГ 11.0 сая төгрөг, ЧД-ийн ЗДТГ 81.7 сая төгрөг, ЧД-ийн НҮГ ОНӨААТҮГ 0.9 сая төгрөг)*
- БЗД-ийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургуулиудад зориулж худалдан авсан 394.0 сая төгрөгийн 2 автобусыг Ахмадын хороо, нэгдсэн эмнэлэгт өгч, хөрөнгө

оруулалтын үр өгөөж, эдийн засгийн ач холбогдол, нэн шаардлага эсэхийг тооцохгүйгээр, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

- Төсвийг зориулалт бусаар зарцуулж улсын төсөвт байгууллагад 109.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. *(БГД-ийн ИТХ 14.7 сая төгрөг, ХУД-ийн ЗД 94.3 сая төгрөг)*
- ЧД-ийн иргэдийн төлөөлөгчдөд олгосон 13.3 сая төгрөгийн Ipad pro11-ийг дахин сонгогдоогүй 3 төлөөлөгчөөс эргүүлэн хурааж аваагүй, тооцоо төлбөр үүсгээгүй байна.
- Өмнөх аудитаар өгсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 59.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна. *(НЖДҮҮДТ 59.9 сая төгрөг, ХУБТөв)*
- Байгууллагын эзэмшлийн гэрчилгээтэй газрыг санхүүгийн тайланд тусгаагүй, шилжиж ирсэн хөрөнгийг бүртгээгүй, газрын нэгж талбарын хэмжээг нэгдсэн цахим системийн мэдээллээс зөрүүтэй бүртгэсэн зэрэг нийт 285.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. *(Тодруулбал, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 40.2 сая төгрөг, Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ 4.4 сая төгрөг, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ 0.2 сая төгрөг)*
- Биет бус хөрөнгө, программ хангамжийг данс бүртгэлд тусгаагүй шууд зардлаар тооцсон 90.8 сая төгрөг, ашиглахгүй болсон 161.6 сая төгрөгийн 12 биет бус хөрөнгийг холбогдох газарт хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй, санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналыг программ хангамжаар бүртгээгүй зэрэг нийт 252.4 сая төгрөгийн зөрчил байна. *(Тодруулбал, НАОБТГ 161.6 сая төгрөг, СХД-ийн НЭЗТЦЗардал 88.7 сая төгрөг, Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ 2.1 сая төгрөг)*
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр балансаас балансt шилжүүлсэн хөрөнгийг ашиглагч байгууллага бүртгэж аваагүй 363.3 сая төгрөг, 2019 онд ашиглалтад орсон 3,268.1 сая төгрөгийн өртөг бүхий барилгыг бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн шинж чанартай худалдаж авсан болон хандиваар ирсэн 14.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн байна. *(Тодруулбал, Замын хөдөлгөөний удирдлагын төв 334.6 сая төгрөг, ЧД-н Теле камерын хяналтын дэд төв ОНӨТҮГ 17.8 сая төгрөг, СХД-н Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ 14.9 сая төгрөг, БГД-н ЗДТГ 10.9 сая төгрөг)*
- Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-д бүртгэлтэй нийт 160 авто тээврийн хэрэгслээс 2,400.0 сая төгрөгийн 24 тээврийн хэрэгсэл нь эвдэрч ашиглалтгүй, *(үүнээс ашиглалтын хугацаа дуусаагүй 615.4 сая төгрөгийн өртөгтэй 6 тээврийн хэрэгсэл), авто баазын хашаанд байгаа нь парк ашиглалтын үр өгөөжгүй байдалтай байна.*
- "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-т бүртгэлтэй тулган үзэхэд байгууллагад ашиглагдаж байгаа 106.4 сая төгрөгийн 7 авто тээврийн хэрэгсэл бүртгэлгүй байна. *(тухайлбал, БЗД-н Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв ОНӨААТҮГ, БЗ Шижир ОНӨААТҮГ 106.4 сая төгрөг, Чандмань Налайх ОНӨААТҮГ, ЧД-н Хүүхэд хөгжлийн цогцолбор ОНӨААТҮГ )*
- Хөрөнгө оруулалтаар хийсэн тохижилтын ажлуудын хөрөнгийг орлого авахдаа багцалсан дүнгээр бүртгэж, нэр төрлийг тодорхой бус, ашиглагдах жилийн хугацааг хэт багаар тооцож, тайлант оны элэгдлийн зардалд тооцсон байна. *(Тодруулбал, БЗД-н ЗДТГ, УСУГ ОНӨААТҮГ)*
- БЗД-н ЗДТГ-ын барилга байгууламж дансанд бүртгэлтэй 658.1 сая төгрөгийн 45 ширхэг гүний худаг нь иргэн, айл өрхийн хашаалсан, карталж баталгаажуулаагүй, ашиглалтгүй, эвдэрхий байна. Уг хөрөнгийг цаашид ашиглалтыг сайжруулах, ашиглахгүй ус гаргахгүй болсныг зохих газарт хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

## 4.9 ӨР ТӨЛБӨР

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,587,386.4 сая төгрөг болж, өмнөх оноос 718,749.8 сая төгрөгөөр өссөн байна.

***Хүснэгт №16. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*** /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 290,405.49 | 322,095.07 | 31,689.58 | 7.0 |
| Дансны өглөг | 173,194.34 | 224,260.79 | 51,066.45 | 4.9 |
| Богино хугацаат зээлийн өглөг | 128.34 | 4,112.81 | 3,984.47 | 0.1 |
| Урьдчилж орсон орлого | 117,082.81 | 93,721.47 | -23,361.34 | 2.0 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 3,578,231.11 | 4,265,291.37 | 687,060.26 | 93.0 |
| Бонд /төгрөг/ | 2,508,396.22 | 2,461,743.16 | -46,653.06 | 53.7 |
| Урт хугацаат зээл /төгрөг/ | 1,069,834.89 | 1,803,548.21 | 733,713.32 | 39.3 |
| **Дүн** | **3,868,636.60** | **4,587,386.44** | **718,749.84** | **100** |
| **Үүнээс, байгууллагын төрлөөр** | | | | |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 666,132.6 | 1,204,285.3 | 538,152.7 | 26.3 |
| Төрийн сан | 2,508,396.2 | 2,461,743.2 | -46,653.0 | 53.7 |
| Төсөвт байгууллага | 649,200.5 | 914,912.5 | 265,712.0 | 19.9 |
| Төсөл/Сан | 44,907.3 | 6,445.5 | -38,461.8 | 0.1 |
| Дүн | **3,868,636.6** | **4,587,386.5** | **718,749.9** | 100 |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 7.1 хувь буюу 274,083.5 сая төгрөгийг богино хугацаат, 92.9 хувь буюу 3,580,693.5 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

### 4.9.1. Дансны өглөг

Өглөг данс 224,260.8 сая төгрөг болж, 51,066.4 сая төгрөгөөр өсөхөд Хотын шуудын уг дансны үлдэгдэл 46,321.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Нийслэлийн өрийн удирдлагын зардлаас НЗД-ын ерөнхий зардлын дансаар дамжуулан төлөх үнэт цаасны хүүгийн хуримтлагдсан үлдэгдэл өмнөх онд 16,321.9 сая төгрөг байснаас 51,140.7 сая төгрөг болж 34,818.8 сая төгрөгөөр өссөн, Нэгдсэн төслийн нэгжийн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор барьцаа хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтээс 37,734.2 сая төгрөгийг зарцуулсан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

### 4.9.2. Богино хугацаат өр төлбөр

Нийт богино хугацаат өр төлбөр данс 322,095.1 сая төгрөг болж, 31,689.5 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: СХД 3,017.2 сая төгрөг, ЧД 3,405.6 сая төгрөг, хотын шууд 24,522.3 сая төгрөгөөр богино хугацаат өр төлбөр тус тус нэмэгдсэн нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Нийслэлийн Засаг даргын ерөнхий зардлын данснаас төлөх үнэт цаасны хүүгийн хуримтлагдсан үлдэгдэл өмнөх онд 16,321.9 сая төгрөг байснаас 51,140.7 сая төгрөг болж 34,818.8 сая төгрөгөөр, Улаанбаатар смарт карт ХХК Нийслэлд 2025 онд шилжиж ирснээр тус байгууллагын 29,755.6 сая төгрөгөөр, Нийслэлийн Захирагчийн ажлын албаны нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр хийгдэж буй угсармал орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах, дулаалах "NAMA FACILITY" төслийн 14,717.9 сая төгрөгөөр тус тус өглөг нэмэгдсэн нь хотын шуудын өглөг нэмэгдэхэд голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

*<u>Аудитын илрүүлэлт:</u>*

*Өр төлбөрийн данстай холбоотой нийт 11,316.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

- Санхүүгийн тайланд 384.1 сая төгрөгийн НДШ, ХХОАТ, НӨАТ-ыг зөрүүтэй тайлагнасан *(БНД-14.03 сая төгрөг, БХ-1.17 сая төгрөг, БГД-4.05 сая төгрөг, СХД-339.8 сая төгрөг,ХУД-25.07 сая төгрөг );*
- Хийгдсэн ажлуудын барьцааны мөнгийг буцаан олгоогүй, холбогдох баримтгүйгээр барьцаа чөлөөлсөн 2,649.1 сая төгрөг */БЗД-1872.58 сая төгрөг, СХД-13.77 сая төгрөг, СБД-161.21 сая төгрөг, ХУД-18.06 сая төгрөг, ЧД-583.48 сая төгрөг /*
- Өр төлбөрийг барагдуулаагүй 1,089.3 сая төгрөг *(Нийтийн тээврийн БГ 708.89 сая.төгрөг, УБЗАА 251.21 сая.төгрөг, НХОГ 129.22 сая.төгрөг)*
- Өглөгийн үлдэгдлийн 5,014.0 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй (*НЗХГ 2,138.3 сая.төгрөг, Хүнс хангамж 2.63 сая.төгрөг, Асгат хүнс 12.75 сая.төгрөг, ХИХУГ 5.97 сая.төгрөг, ТЦХ ХХК 87.73 сая.төгрөг, УБОС ХХК 13.65 сая.төгрөг, УБ ЗЗАГ 68.15 сая.төгрөг, ОУХЛТөв 628.04 сая.төгрөг, НХОГ 614.67 сая.төгрөг, УСУГ ОНӨААТҮГ 66.69 сая.төгрөг, НТХС 133.88 сая.төгрөг г м*

### 4.9.3. Богино хугацаат зээл

Богино хугацаат зээлийн өглөг 4,112.8 сая төгрөг болж, 3,984.5 сая төгрөгөөр өссөн нь Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ нь шингэрүүлсэн шатдаг хийн түлшийг хэрэглээнд нэвтрүүлж байгаатай холбогдуулан захиалагчийн хяналтыг тавьснаар 3,911.9 сая төгрөгийн богино хугацаат зээлийн өглөг нэмэгдсэн нь голлох нөлөөллийг үзүүлсэн.

### 4.9.4. Урьдчилж орсон орлого

Урьдчилж орсон орлого 93,721.5 сая төгрөг болж 23,361.3 сая төгрөгөөр буурсан нь Хотын шуудын хувьд 25,783.7 сая төгрөгөөр буурсан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна. (*Улаанбаатар смарт карт ХХК нийслэлд шилжин ирснээр тус байгууллагын 17,542.9 сая төгрөгийн урьдчилж орсон орлого нэмэгдсэн, Улаанбаатар зам засвар арчлалтын газар 33,580.0 сая, Зорчигч тээвэр 3 ОНӨААТҮГ 25,547.4 сая төгрөг)*

### 4.9.10. Урт хугацаат үнэт цаасны өр төлбөр

Урт хугацаат үнэт цаасны өр төлбөрт Улсын Их Хурлын 2024 оны 17 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 201, 264, 265 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 47, 48, 89 дүгээр тогтоолуудын дагуу гадаадын зах зээлд 500.0 сая ам.доллар, дотоодын зах зээлд 1.0 их наяд төгрөгийн үнэт цаас гаргах зөвшөөрлийг авсны дагуу 2024 онд 2,508,396.2 сая төгрөгийн үнэт цаас гаргасан.
Засгийн газрын 2024 оны 201 дүгээр тогтоолоор дотоодын зах зээлд гаргах 500.0 тэрбум төгрөг хүртэлх бондыг “БиДиСЕК ҮЦК” ХК, “ЭмАйСиСи ҮЦК” ХХК, “Таванбогд Капитал ҮЦК” ХХК, “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК, “Голомт капитал ҮЦК” ХХК зэрэг андеррайтер компаниудтай хамтран ажиллаж, нээлттэй хэлбэрээр 3 транчтайгаар зах зээлд арилжсан. Эндээс:

- 300.0 тэрбум төгрөгийг 3 жилийн хугацаатай, 14%-ийн хүүтэйгээр;
- 100.0 тэрбум төгрөгийг 2 жилийн хугацаатай, 13%-ийн хүүтэйгээр;
- 100.0 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай, 12%-ийн хүүтэйгээр

дотоодын томоохон банкнуудаас 2024 онд нийт 500.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. 2025 онд 100.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийж, 400.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор гадаадын зах зээлд гаргах 500.0 сая ам.доллар хүртэлх бондыг 2 транчтай, 7.75%-ийн хүүтэй, 2.75 жилийн хугацаатай зах зээлд хаалттай хэлбэрээр Австри улсын Вена хотын Wiener Börse бирж дээр 2024 оны

10 дугаар сарын 30-ны өдөр болон 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулагдаж Blackrock, Pimco зэрэг олон улсын томоохон хөрөнгө оруулалтын сангуудаас хөрөнгө босгосноор 2024 онд 2,008,396.2 сая төгрөгийн гадаад үнэт цаас тайлагнасан. Тайлант онд уг бондын төлбөрт 15,526.4 сая төгрөгийг төлж, хүүгийн төлбөрт 187,171.7 сая төгрөгийг төлсөн байна. Гадаад үнэт цаасны үлдэгдэлд 2025 онд ханшийн зөрүүгийн гарз 68,205.0 сая төгрөгийг тайлагнасан байна.

Тайлант онд урт хугацаат үнэт цаас дансанд дотоодын зах зээлд гаргасан 683,413.2 сая төгрөг, гадаадын зах зээлд гаргасан 1,778,330.0 сая төгрөгийн үнэт цаасны үлдэгдэл тус тус тайлагнагдаж байна.

***Хүснэгт №17. Нийслэлийн үнэт цаасны үлдэгдэл*** /сая төгрөгөөр/

| № | Үнэт цаасны нэр | Хүү | Эцсийн үлдэгдэл 2025.12.31 | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төгрөг | Доллар | Ханш | Мөнгөн дүн |
| 1 | Сэлбэ бонд | 7.75% | - | 500.0 | 3,556.66 | 1,778,330.0 |
| 2 | Улаанбаатар бонд | 14% | 300,000.0 | - | | 300,000.0 |
| 3 | Улаанбаатар бонд | 13% | 100,000.0 | - | | 100,000.0 |
| 4 | УБ хот ЭХХС бонд 1 | 8.03% | - | 59.1 | 3,420.92 | 202,166.31 |
| 5 | УБ хот ЭХХС бонд 2 | 6.30% | - | 23.75 | 3,420.92 | 81,246.85 |
| | | | **400,000.0** | **582.85** | | **2,461,743.16** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 4.9.6 Урт хугацаат зээл

Тайлант онд урт хугацаат зээл 733,713.3 сая төгрөгөөр нэмэгдсэнээр, үлдэгдэл 1,803,548.2 сая төгрөг болсон байна. Үүнээс гол нөлөөллийг дурдвал:

- Сангийн яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хооронд байгуулсан дамжуулан зээлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн эхний үлдэгдэл 594,852.1 сая, эцсийн үлдэгдэл 716,758.0 сая төгрөг болж 121,905.9 сая төгрөг;
- Улаанбаатар хөгжлийн корпорацын охин компани болох Улаанбаатар Энержи ХХК-ийн “Батарей хураагуурын станц” төслийн санхүүжилт 286,193.7 сая төгрөг;
- Сэлбэ хорин минутын хот корпорац ХК-ийн “Сэлбэ дэд төв” төслийн санхүүжилтийг захиалагчаас дамжуулан олгохоор хүлээн авсан эх үүсвэрийг гүйцэтгэлээр хаагдах хүртэлх хугацаанд уг дансанд 293,135.8 сая төгрөг; тус тус нэмж бүртгэсэнтэй холбоотойгоор өссөн байна

***Хүснэгт №18. СЯ болон НЗДТГ хооронд байгуулсан дамжуулан зээл*** /сая төгрөгөөр/

| Зээлийн нэр | ДЗ-ын дугаар | Энгийн эх үүсвэртэй зээл | Хөнгөлөлттэй эх үүсвэртэй зээл | Зээлийн нийт дүн | Валют | Зээлдүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|
| "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-Төсөл 1 | OL-83097EIB | 21,000.00 | - | 21,000.00 | EUR | Азийн хөгжлийн банк |
| | OL-3098MON(SF) | 27,500.00 | 22,500.00 | 50,000.00 | USD | |
| Хот байгуулалтын салбарын төсөл | OL-2301MON-08 | 8,698.00 | - | 8,698.00 | SDR/MNT | |
| УБ хотын нийтийн аж ахуйг сайжруулах төсөл | OL-2937MOG | 12,300.00 | - | 12,300.00 | SDR | Олон Улсын Хөгжлийн Ассоциаци |
| | OL-3890MOG | 12,100.00 | - | 12,100.00 | SDR | |
| "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг | OL-3525MON(SF) | 37,110.00 | 29,240.00 | 66,350.00 | USD | Азийн хөгжлийн банк |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| дэмжих хөтөлбөр-Төсөл 2 | OL-83873-EIB | 29,000.00 | - | 29,000.00 | EUR | Европын хөрөнгө оруулалтын банк |
| "Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл | OL-3694-MON | 60,000.00 | 20,000.00 | 80,000.00 | USD | Азийн хөгжлийн банк |
| "Ногоон - Улаанбаатар орон сууц төсөл" | 8348 GCF | 95,000.00 | - | 95,000.00 | USD | Азийн хөгжлийн банк-Ногоон уур амьсгалын сан |
| "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-Төсөл 3 | OL-3946-MON | 25,050.00 | 13,639.00 | 38,689.00 | USD | Азийн хөгжлийн банк |
| Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл | OL-46581 | 9,700.00 | - | 9,700.00 | USD | Европын сэргээн босголт хөгжлийн банк |
| "Улаанбаатар хотын тогтвортой авто зам тээвэр төсөл" | OL-9257 | 100,000.00 | - | 100,000.00 | USD | Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк |
| "Ногоон-Улаанбаатар орон сууц төсөл" | EBRD-50702 | 20,000.00 | - | 20,000.00 | USD | Европын сэргээн босголт хөгжлийн банк |

*Эх сурвалж: Нийслэлийн үнэт цаас гаргалтын мэдээлэл, эргэн төлөлт, эх үүсвэрийн зарцуулалтын талаарх мэдээ*

## 4.10. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,272,194.4 сая төгрөг болж, өмнөх оноос 392,552.1 сая төгрөгөөр өссөн байна.

***Хүснэгт №19. Засгийн газрын хувь оролцоо*** */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 996,624.0 | 999,125.7 | 2,501.7 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 840,154.5 | 946,117.2 | 105,962.7 |
| Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/ | | 167.2 | 167.2 |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 749,857.1 | 886,005.1 | 136,148.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,886,152.7 | 2,043,065.2 | 156,912.5 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 406,853.9 | 397,713.9 | -9,140.0 |
| **Дүн** | **4,879,642.3** | **5,272,194.3** | **392,552.1** |

*Эх сурвалж: Нийслэлийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 999,125.7 сая төгрөг болж, 2,501.7 сая төгрөгөөр өссөн байна. Орон нутгийн төсвийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын өмч 108,464.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, нэмж төлөгдсөн капитал 167.2 сая төгрөг, эздийн өмчийн бусад хэсэг 136,148.0 сая төгрөг,

хуримтлагдсан үр дүн данс 156,912.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 9,140.0 сая төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн оруулсан капитал данс 108,464.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд Нийслэлийн харьяа байгууллага, орон нутгийн өмчит Зорчигч тээвэр-2 ОНӨААТҮГ 25,156.9 сая төгрөг, Зорчигч тээвэр-4 ОНӨААТҮГ 1,525.3 сая төгрөг, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ 23,630.1 сая Эмээлт-Эко аж үйлдвэрийн парк ХК 18,420.1 сая төгрөг, Нийслэлийн соёлын төв өргөө ОНӨААТҮГ 14,607.2 сая төгрөг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 8,564.7 сая төгрөг, Хүннү хотын хөгжлийн корпорац 4,000.0 сая төгрөг, Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮГ 3,879.3 сая төгрөг, Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК 3,000.0 сая төгрөг, Тархмал эрчим хүчний дэд бүтэц 3,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.
Нэмж төлөгдсөн капитал дансны үлдэгдэл 167.2 сая төгрөг болж нэмэгдсэн нь тайлант онд Нийслэлийн өмчит Зорчигч тээвэр-1 ОНӨААТҮГ-т 167.2 сая төгрөгийн капитал засвар хийснийг, данс бүртгэлд бүртгэснээс шалтгаалжээ. Эздийн өмчийн бусад хэсэгт дансны үлдэгдэл 886,005.1 сая төгрөг болж 136,148.0 сая төгрөгөөр өссөн байна.
Үүнд: Нийслэлийн харьяа орон нутгийн байгууллагууд 106,418.9 сая төгрөг, СХД 29,729.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь гол нөлөөллийг үзүүлсэн байна. Тухайлбал,

- Сонгинохайрхан дүүргийн дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ-29,729.0 сая төгрөг;
- Зорчигч тээвэр – 3 ОНӨААТҮГ -15,444.6 сая төгрөг;
- Эмээлт-Эко аж үйлдвэрийн парк ХК -8,816.7 сая төгрөг;
- Улаанбаатар орон сууцжуулалт ХХК -24,473.9 сая төгрөг;
- Нийслэлийн орон сууцны корпорац ХК- 10,600.9 сая төгрөг ;
- Ус сувгийн удирдах газар -29,249.1 сая төгрөг;
- Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК- 17,833.7 сая төгрөгөөр; тус тус нэмэгдсэн байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл тайлант онд 2,043,065.2 сая төгрөг болж 156,912.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.
Нийслэлийн харьяа байгууллагууд хувьд оны эхний үлдэгдлээс томоохон төслийг 2024-2025 он дамжин хэрэгжүүлэхээр батлагдсаны дагуу санхүүжүүлсэнтэй холбоотойгоор Төрийн сангийн тайлан 636,312.2 сая төгрөгөөр алдагдалтай гарсан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 397,713.9 сая төгрөг болж, 9,140.0 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны хувьд нийслэлийн харьяа байгууллагууд 8,681.2 сая төгрөг, дүүргүүд 458.8 сая төгрөгийн дахин үнэлгээтэй хөрөнгө данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ.

## 4.11. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БОЛОН ХАРЬЯА НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 9 дүүргийн ТТЗ, тэдгээрийн харьяа 139 ТШЗ, НТЕЗ түүний харьяа нийслэлийн орон нутгийн ТШЗ 28, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой 52 хуулийн этгээд, төслийн нэгж, сан, зардлын 8 данс, ТЕЗ-ийн 2, нийт 238 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулахаас 137 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж *(өөрчлөлтгүй 108, хязгаарлалттай 29)*, 100 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 1 байгууллага *(СБД-ийн Бага хандгайт ОНӨААТҮГ)* үйл ажиллагаа явуулаагүй тул аудитад хамрагдаагүй байна.

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон харьяа нэгж байгууллагын санхүүгийн аудитаар нийт 1,884,474.1 сая төгрөгийн 1,222 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 460,849.2 сая төгрөгийн 218 алдааг залруулсан.

Санхүүгийн аудитын асуудлаар нийт 127,418.3 сая төгрөгийн 737 зөрчил илэрснээс 1,179.2 сая төгрөгийн зөрчилд 84 төлбөрийн акт, 72,395.1 сая төгрөгийн зөрчилд 147 албан шаардлага, 52,994.8 сая төгрөгийн зөрчилд 502 зөвлөмж, 849.2 сая төгрөгийн зөрчил гаргасан 4 албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд нийт 1,296,206.6 сая төгрөгийн 267 зөрчил илэрснээс 42.3 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт, 264,690.6 сая төгрөгийн зөрчилд 121 албан шаардлага, 1,029,761.5 сая төгрөгийн зөрчилд 131 зөвлөмж өгч, 1,712.2 сая төгрөгийн зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүллээ.

### 4.11.1. Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 9 дүүргийн ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд бүрэн хамрагдсан байна. Дүүргүүдийн ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” 1 (*НД*), “Өөрчлөлтгүй” 8 (*БГД, БНД, БЗД, БХД, СБД, СХД, ХУД, ЧД*) санал дүгнэлт өгсөн байна.

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар орон нутгийн төсвийн 58 байгууллага (*дүүргүүдийн ЗДТГ, ИТХ, ХААА, ДАА, ЖДҮДТ, Соёлын төв гм*), орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 55 байгууллага, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын болон хот тохижилтын зардал, сан, төсөл зэрэг 25 данс, 9 дүүргийн төрийн сан, нийт 148 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулсан. Нийт 47 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 35 байгууллагад “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт, 12 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, 100 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн. СБД-ийн Бага хандгайт ОНӨААТҮГ нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй тул аудитад хамрагдаагүй байна. Дүүргийн ТТЗ-ийн харьяа дараах байгууллагуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Багануур, Багахангай, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд ТКХТ ОНӨТҮГ, Баянгол тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Баянгол дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ, Нийслэлийн Баруун бүсийн зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ, ЧДХОББДТ ОНӨААТҮГ зэрэг 9 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг шинээр байгуулсан.
- Баянгол дүүргийн Гэр бүл, ёслолын ордон ОНӨТҮГ нь Баянгол дүүргийн Соёл урлаг, ёслол хүндэтгэлийн ордон ОНӨТҮГ, Налайх дүүргийн Цэцэрлэгжүүлэлтийн албыг Налайх хотын хөгжлийн корпорац ОНӨААТҮГ, Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ-ыг Чингэлтэй цогцолбор ОНӨТҮГ гэж тус тус нэрийг өөрчилсөн байна.

*Хүснэгт №20. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын дүгнэлтийн хэлбэр*

| ТТЗ-ийн нэр | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай |
|---|---|---|
| Баянзүрх дүүргийн Засаг дарга | ИТХ | ЗДТГ |
| | Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв ОНӨААТҮГ | Баянзүрх Шижир ОНӨААТҮГ |
| | Баянзүрх Эко тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ | |
| Чингэлтэй дүүргийн Засаг дарга | ЗДТГ | ЧД-ийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ |
| | ИТХ | |
| | ЧДХОББДТ ОНӨААТҮГ | |
| Налайх дүүргийн Засаг дарга | ЗДТГ | ИТХ |
| | Налайх Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ | |
| | Чандмань Налайх ОНӨААТҮГ | |
| | Налайх хангамж, нийтлэг үйлчилгээний төв ОНӨААТҮГ | |
| | Налайх Гэрэлтүүлэг чимэглэлийн алба ОНӨААТҮГ | |
| | Налайх хотын хөгжлийн корпораци ОНӨААТҮГ | |
| Багануур дүүргийн Засаг дарга | ИТХ | ЗДТГ |
| | Багануур залуус төв ААТҮГ | |
| | Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ | |
| | Багануур ус ААТҮГ | |
| | Багануур тохижилт ААТҮГ | |
| Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга | ЗДТГ | |
| | ИТХ | |
| | Захиалагчийн алба ОНӨААТҮГ | |
| | Тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ | Баруун бүсийн зам засвар, арчлалт ОНӨААТҮГ |
| Баянгол дүүргийн Засаг дарга | | ЗДТГ |
| | | ИТХ |
| | | Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ |
| | | Баянгол тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ |
| Хан-Уул дүүргийн Засаг дарга | ЗДТГ | ИТХ |
| | Тохижилт, үйлчилгээний төв ОНӨААТҮГ | Эко хотын тээвэр ОНӨААТҮГ |
| | Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ | |
| | Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ | |
| | Хан Эко тээвэр ОНӨААТҮГ | |
| | Хан-Уул агро ОНӨААТҮГ | |
| Сүхбаатар дүүргийн Засаг дарга | ЗДТГ | |
| | ИТХ | |
| | Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ | |
| | Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ | |
| Багахангай дүүргийн Засаг дарга | ЗДТГ | |
| | ИТХ | |
| | Багахангай Илч-Орд ОНӨААТҮГ | |
| | Багахангай тохижилт ОНӨААТҮГ | |

Дүүргүүдийн ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 117,157.6 сая төгрөгийн 643 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 45,033.5 сая төгрөгийн 105 алдааг залруулсан.

Санхүүгийн аудитын асуудлаар нийт 21,949.2 сая төгрөгийн 397 зөрчил илэрснээс нөхөн төлүүлэх 542.5 сая төгрөгийн 41 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг таслан зогсоох 5,970.4 сая төгрөгийн 67 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 14,978.5 сая төгрөгийн 287 зөвлөмж, 2 албан тушаалтанд хариуцлага тооцох 457.8 сая төгрөгийн албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд нийт 50,174.9 сая төгрөгийн 141 зөрчил илэрснээс 16.9 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 29,499.8 сая төгрөгийн зөрчилд 71 албан шаардлага, 20,658.2 сая төгрөгийн зөрчилд 64 зөвлөмж өгсөн.

### 4.11.2. Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн аудит

Орон нутгийн 28 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 23 “Өөрчлөлтгүй”, 5 “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг тус тус өгсөн байна.

***Хүснэгт №21. Орон нутгийн төсвийн өөрчлөлттэй дүгнэлт авсан байгууллагууд***

| | ***Хязгаарлалттай санал дүгнэлт*** |
|---|---|
| 1 | Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар |
| 2 | Нийслэлийн Архивын газар |
| 3 | Нийслэлийн Дотоод аудитын газар |
| 4 | Нийслэлийн Замын хөгжлийн газар |
| 5 | Хүннү хотын Захирагчийн ажлын алба |

Нийслэлийн харьяа дараах байгууллагуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн захирагчийн албыг, Агро-сити эдийн засгийн тусгай бүсийн захирагчийн албыг шинээр байгуулсан.

Нийслэлийн харьяа 28 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 262,684.3 сая төгрөгийн 191 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 68,717.0 сая төгрөгийн 39 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Санхүүгийн аудитын асуудлаар нийт 11,748.5 сая төгрөгийн 101 зөрчил илэрснээс 277.9 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 8,356.3 сая төгрөгийн зөрчилд 26 албан шаардлага, 3,114.3 сая төгрөгийн зөрчилд 65 зөвлөмж өгсөн байна.

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд нийт 182,218.8 сая төгрөгийн 51 зөрчил илэрснээс 11.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 179,156.2 сая төгрөгийн зөрчилд 26 албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 225.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2,825.7 сая төгрөгийн зөрчилд 22 зөвлөмж өгсөн байна.

### 4.11.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн аудит

Орон нутгийн өмчит болон тэдгээрийн оролцоотой нийт 52 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг аудитад бүрэн хамруулснаас, “Өөрчлөлтгүй” 41, “Хязгаарлалттай” 11 санал дүгнэлтийг тус тус өгсөн.

Нийслэлийн орон нутгийн өмчит болон тэдгээрийн оролцоотой 52 хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 567,964.1 сая төгрөгийн 345 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 346,764.9 сая төгрөгийн 71 алдааг залруулсан.

Санхүүгийн аудитын асуудлаар нийт 15,600.7 сая төгрөгийн 214 зөрчил илрүүлснээс 351.7 сая төгрөгийн 32 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,496.3 сая төгрөгийн зөрчилд 44 албан шаардлага, 2 албан тушаалтанд хариуцлага тооцох 391.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 11,361.4 сая төгрөгийн зөрчилд 136 зөвлөмж өглөө.

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд нийт 205,598.5 сая төгрөгийн 60 зөрчил илэрснээс, 14.4 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 56,034.5 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага, 1 албан тушаалтанд 1,486.5 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлж, 148,063.1 сая төгрөгийн зөрчилд 30 зөвлөмж өглөө.

***Хүснэгт.№22 ОНӨ болон тэдгээрийн оролцоотой ХЭ-ийн өөрчлөлттэй дүгнэлт авсан байгууллагууд***

| | ***Хязгаарлалттай санал дүгнэлт*** |
|---|---|
| 1 | Олон улсын худалдаа логистикийн төв ХК |
| 2 | Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК |
| 3 | Улаанбаатар смарт карт |
| 4 | Нийслэлийн Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮГ |
| 5 | Улаанбаатар түншлэл төв ХХК |
| 6 | Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ |
| 7 | Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ |
| 8 | Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ |
| 9 | Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ |
| 10 | Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ |
| 11 | Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк ХК |

Орон нутгийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Тайлант онд НИТХ-ын 2025 оны 25/153 дугаар тогтоолоор Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, Туулын хурдны зам ОНӨААТҮГ болгон өөрчилсөн байна.
2. ТТЗ-ийн хүрээний орон нутгийн байгууллагуудаас; Багануур гэрэлтүүлэг, чимэглэл ААТҮГ, БЗД-ийн Иргэд, олон нийтэд үйлчлэх төв, Нийтлэг үйлчилгээний газар нэг ОНӨААТҮГ, Нийтлэг үйлчилгээний газар хоёр ОНӨААТҮГ, Нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ, Нийтлэг үйлчилгээний газар дөрөв ОНӨААТҮГ зэрэг 6 байгууллага тайлант онд татан буугдсан.
3. Улаанбаатар смарт карт ХХК-ийн хувьцааг эзэмшигч БНСУ-ын Ти Мони компанийн 55 хувийн хувьцааг НИТХ-ын 2024 оны 62 дугаар тогтоолоор худалдан авсан.
4. Улаанбаатар түншлэл төв ХХК, Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ, Нийслэлийн Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ, Улаанбаатар орон сууцжуулалт ХХК, Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК, КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар ОНӨААТҮГ, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ, Тархмал эрчим хүчний

дэд бүтэц ХХК, Дулааны тавдугаар цахилгаан станц ОНӨААТҮГ зэрэг 9 байгууллага шинээр байгуулагдсан.

5. Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 16.2, 16.5 болон Засгийн газрын 2024 оны 114 тогтоолын дагуу Хүннү хотын хөгжлийн корпорац ХХК шинээр байгуулагдсан.
6. Соёлын төв өргөө төсвийн байгууллагын статустай байсныг ОНӨААТҮГ болгон өөрчилсөн.
7. Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Нэгдсэн төслийн удирдлагын газар болж, нэр нь солигдсон.
8. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ, Багахангай үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ-ууд нь өмчийн хэлбэрийг хувьцаат компани (ХК) болгон өөрчилсөн байна.

Нийслэлийн харьяа нийт 52 орон нутгийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаагаас, аж ахуйн нэгжийн тайлангаар 45, төсөвт байгууллагын тайлангаар 7 орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.  Аж ахуйн нэгжийн тайлан гаргаж буй 45 байгууллагын 24 нь ОНӨААТҮГ, 21 нь ХХК статустай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/921 дүгээр захирамжаар 2025 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг 19 орон нутгийн өмчит байгууллагатай гэрээ байгуулж, баталсан байна. “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2025 оны зорилт”-ын хүрээнд 725.2 тэрбум төгрөгийн орлого, 794.6 тэрбум төгрөгийн зардал, 25.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Тайлант онд  747.7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 760.0 тэрбум төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 2.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ашигтай ажилласан 20 орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь 25.8 тэрбум төгрөгийн ашгийг бүрдүүлж, алдагдалтай ажилласан 11 *(УСУГ ОНӨААТҮГ, ХИХУГ ОНӨААТҮГ, ОСНААУГ ОНӨААТҮГ, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК, Улаанбаатар орон сууцжуулалт ХХК, Хот тохижилтын газар, Дулааны цахилгаан станц 5 ОНӨААТҮГ, Улаанбаатар Энержи ХХК, Хот төлөвлөлт, судалгааны институт, Улаанбаатар түншлэл ХХК, Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ)* орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь 41.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

### 4.11.4. Арга хэмжээ, сан, зардлын дансдад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний ГХУСАЗНСЗ, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо, НОК болон  төсөл, зардлын 3, сангийн 2, нийт 8 дансанд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитаар нийт 1,579.9 сая төгрөгийн  16 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 6.8 сая төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Санхүүгийн аудитын асуудлаар нийт 1,305.6 сая төгрөгийн 13 зөрчил илрүүлснээс 7.1 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 826.2 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 472.3 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж, нийцлийн аудитын асуудлаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 267.6 сая төгрөгийн 2 зөвлөмжийг тус тус өгсөн.

## 4.12. НТЕЗ-ИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаар нийт 77,089.2 сая төгрөгийн 13 зөрчил илрүүлснээс 274.9 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулж, 53,745.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 23,068.4 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар 857,998.9 сая төгрөгийн 13 алдаа зөрчил илрүүлснээс 52.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 857,946.9 сая төгрөгийн 12 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

***<u>Илрүүлэлт:</u>***

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 26/05 дугаар тогтоолоор арван хариуцлагатай хувьцаат компанийн дүрмийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр 18,500.0 сая төгрөгийг баталсан боловч, урсгал үйл ажиллагааны зардалд 7,617.0 сая төгрөгийг зарцуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
- Нийслэл, дүүргийн төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагад санхүүгийн тайланд аудит хийх явцад орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө болон эргэлтийн бус хөрөнгийн орлого зарлага, үлдэгдлийг тулган баталгаажуулах зорилгоор Нийслэлийн өмчийн харилцааны газарт удаа дараа хандсан боловч (*сүүлийн 3 жил*), нэгтгэсэн судалгаа, тайлан мэдээллийг бүрэн ирүүлээгүй тул төсөв захирагчийн санхүүгийн тайлан дахь хөрөнгийг тулган баталгаажуулах боломжгүй байна.
- Авлагын дансны үлдэгдэлд дөрвөөс дээш жилийн насжилттай 43,446.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажил удаашралтай, олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
- Урьдчилгаа дансанд Улаанбаатар спорт менежмент ХК-ийн 2020 оны 2,434.1 сая, Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2015 оны 248.5 сая төгрөгийн олон жил дамжсан ажлууд бүртгэлтэй байна.
- Монгол банкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршиж байгаа 2,311.8 сая төгрөгийн хөрөнгөд эрсдэл үүссэн асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Дотоод хяналтыг хэрэгжүүлэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 5 албан шаардлагыг хүргүүлэв.

## 4.13 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 78,785.0 сая төгрөгийн 8 зөрчил илрүүлж, 46,821.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 31,963.7 сая төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлснийг 68.8 хувьтай хэрэгжүүлсэн байна. Дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Монгол банкны шалгуур үзүүлэлт хангахгүй банканд байршсан мөнгөн хөрөнгийг үлдэгдлийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлэх;
- Олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах, авлагын тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулах;
- Орон нутгийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн дүрмийн санг нэмэгдүүлэх болон НТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагааны онцлогт тохирсон НББ-ийг харьяа байгууллагуудын НБББББ-д тусгаж, шинэчилсэн хууль журамд нийцүүлэх;

## 4.14 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийслэлийн Засаг даргаар Нийслэлийн Дотоод аудитын алба нь  2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. НДАА-аас тайланд онд төлөвлөгөөт 31, он дамжин хэрэгжсэн 5, захиалгат 6, нийт 42 дотоод аудит, хяналт шалгалтыг хийж хэрэгжүүлсэн байна. Дотоод аудит,хяналт шалгалтаар нийт 152,545.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 28 байгууллагад 4,820.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,934.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 145,791.1 сая төгрөгийн зөрчилд цаашид давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгч ажилласан байна.

### 4.14.1 Дараагийн аудитаар анхаарах асуудлууд

- Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгүүдийг санхүүгийн тайланд тусгасан эсэх болон Нийслэлийн харьяа төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөнийг (2025.12.31 өдрөөрх ) тулган баталгаажуулах;
- Нийслэлийн харьяа төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын урьдчилгаа дансны үлдэгдлийн ангилал, зориулалт, хугацаа хэтрэлт, насжилт, түүнд тавих дотоод хяналтад нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх;
- Сангийн яаманд бүртгэлтэй 606 данснаас тайлант онд огт гүйлгээ хийгдээгүй 122 данс байна. Эдгээр дансыг цаашид ашиглах эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан тайланг ирүүлэх;
- НХОГ, АЗХГ-ын бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан, комиссын акт нь гарсан зам талбай, шугам сүлжээ, урсгал засвар зэрэг хөрөнгүүдийг ашиглагч байгууллагуудад хүлээлгэж өгөх ажлыг давтан шалгах;
- НХОГ-аас ирүүлсэн, хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа шүүхийн маргаантай 1,620.3 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, гэрээ цуцлагдсан 7,720.7 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, санхүүжилт зогссоноос шалтгаалсан 8,854.3 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ бүртгэлтэй эсэхийг давтан үзэх;

# 5.АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## 5.1. ДҮГНЭЛТ

1. Өмнөх онуудад хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулалт болон зам талбайн засвар шинэчлэлтийн хийгдэж дууссан ажлууд, комиссын актаар баталгаажуулсан хөрөнгө оруулалтын ажлуудыг ашиглагч байгууллагуудад бүрэн хүлээлгэж өгөөгүй, зарим ажлууд удаашралтай, шүүхийн маргаантай, санхүүжилт зогссоноос ажил дуусаагүй зэрэг хөрөнгө оруулалтын ажлууд байна.
2. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 238 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулахаас 137 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж (өөрчлөлтгүй 108, хязгаарлалттай 29), 100 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 1 байгууллага *(Сүхбаатар дүүргийн Бага хандгайт ОНӨААТҮГ)* тайлант онд үйл ажиллагаа явуулаагүйгээс аудитад хамрагдаагүй байна.
3. Урт хугацаат гадаад үнэт цаасны 1,567.4 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зарцуулагдахгүйгээр арилжааны банкнуудад хадгаламж хэлбэрээр байршуулсан байна.
4. Дуусаагүй барилга байгууламж дансанд 10 гаруй жилийн насжилттай хөрөнгийн ашиглалт, үр өгөөж, үр дүн тодорхой бус 12.8 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
5. Монгол банкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Үндэсний хөрөнгө оруулалтын банканд нийт 2.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө эрсдэлтэй хэлбэрээр байршин, шинээр байгуулсан эвлэрлийн гэрээний дагуу ажил хийгдээгүй байна.
6. Авлага дансны үлдэгдэлд байгаа 4-өөс дээш жилийн насжилттай 43.5 тэрбум төгрөгийн авлага нь нийт авлагын 19.5 хувийг эзэлж байгаа бөгөөд насжилт өндөртэй авлагыг бууруулах ажил удаашралтай, уг авлага нь найдваргүй болох эрсдэлтэй байна.
7. НИТХ-ын 2025 оны 26/05 дугаар тогтоолоор 10 ХХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхээр 18.5 тэрбум төгрөгийн хөрөнгө баталсан боловч урсгал үйл ажиллагааны зардалд 7.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.
8. Бусад эргэлтийн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтаар хийгдэж дууссан ажлуудын комиссын акт гарсан боловч ашиглагч байгууллагуудад хүлээлгэж өгөөгүй зам талбай, шугам сүлжээ, урсгал засвар зэрэг 54 төсөл арга хэмжээ бүртгэлтэй байна.
9. Татан буугдсан орон нутгийн өмчит байгууллагуудад ашиглалтын хугацаа нь дуусаагүй, зориулалтын дагуу ашиглах боломжгүй, 7.8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө байна.
10. Гадаад зах зээлд 500.0 сая ам.доллар, дотоод зах зээлд 1.0 их наяд төгрөгийн урт хугацаат үнэт цаасны эргэн төлөлтийг ЗГ-ын 265 дугаар тогтоолын дагуу тайлант онд үндсэн төлбөрт 115.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 187.2 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.
11. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн тоо, мөнгөн дүн буураагүй, нийт илэрсэн зөрчлийн 25.1 хувийг мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн зөрчил эзэлж байгаа нь Нийслэл, дүүргийн Төрийн сангийн зарлагын гүйлгээнд тавих хяналт хангалтгүйг харуулж байна.

12. Сангийн яаманд бүртгэлтэй, арилжааны банканд байгаа 606 данснаас тайлант онд огт гүйлгээ хийгдээгүй 122 данс, үүнээс цаашид ашиглах эсэх нь тодорхой бус, эргэлзээтэй 45 данс байна.
13. Нийслэлийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон эргэлтийн бус хөрөнгийн орлого зарлага, үлдэгдлийг тулган баталгаажуулах зорилгоор Нийслэлийн өмчийн харилцааны газарт сүүлийн 3 жил дараалан хандсан боловч нэгтгэсэн судалгаа, дэлгэрэнгүй тайлан мэдээллийг бүрэн ирүүлэхгүй байгаагаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан дахь хөрөнгөд хөндлөнгийн тулган баталгаажуулалт хийх боломжгүй нөхцөл үүссэн байна.
14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүлээлгэн өгсөн үндсэн хөрөнгийг эзэмшигч болон ашиглагч байгууллага нь санхүүгийн тайланд дутуу бүртгэсэн, нөхөрлөлд төсвөөс хөрөнгө бэлтгэсэн.
15. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны 9 дүүргийн төсвийн төвлөрүүлэн захирагч, хотын шууд болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн байгууллагуудад хийсэн санхүү, нийцлийн асуудлаар тайлант онд 422.2 тэрбум төгрөгийн залруулсан алдаа, 488.9 тэрбум төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн байна.

## 5.2. ЗӨВЛӨМЖ

### 5.2.1. НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:

- Нийслэлийн дотоод, гадаад үнэт цаас гаргах, зарцуулахтай холбогдон гарсан ЗГ-ын тогтоол, НИТХ-ын тогтоолуудын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хэлэлцэн, олон нийтийг нээлттэй мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын хүрээнд томоохон төсөл, арга хэмжээ, ажлуудын бодит хэрэгцээ шаардлага, нийгэмд хүлээгдэж байгаа хүлээлт, үр ашигт илүү анхаарч ажиллах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх;

### 5.2.2. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАД:

- Харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналд тавих хяналтыг сайжруулах;
- Татан буулгаж байгаа байгууллагуудын хөрөнгийн ашиглалтад анхаарах, хөрөнгийн насжилт, үр ашигт тавих хяналтыг сайжруулах;
- Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бодитойгоор тооцож, үр дүнд бий болсон хөрөнгийн бүртгэл, ашиглалтад тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;
- Мөнгөн хөрөнгийн гүйлгээнд Төрийн сангаас тавих хяналтыг сайжруулж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах ажлыг зохион байгуулах;
- Олон жилийн насжилттай 12.8 тэрбум төгрөгийн дуусаагүй барилга байгууламжуудыг хөрөнгийн үнэ цэнийн бууралтаас хамгаалах ажлыг зохион байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Гадаад зах зээл дээрээс татсан санхүүжилтийн үлдэгдэл 1,567.4 тэрбум төгрөгийг зөв зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах;

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (сая төгрөгөөр)

| | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Төсвийн ерөнхийлөн захирагч** | | | | | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн Засаг дарга | 2 | 326.9 | 1 | 52.0 | 1 | 274.9 | 1 | 274.9 | | | | |
| **Төсвийн ерөнхийлөн захирагчийн дүн** | | **2** | **326.9** | **1** | **52.0** | **1** | **274.9** | **1** | **274.9** | **-** | **-** | **-** | **-** |
| **Төсвийн төвлөрүүлэн захирагч** | | | | | | | | | | | | | |
| 1 | Сүхбаатар дүүрэг | 2 | 6.0 | - | - | 2 | 6.0 | 2 | 6.0 | | | | |
| 2 | Баянзүрх дүүрэг | 9 | 1,215.5 | 5 | 51.7 | 4 | 1,163.7 | 9 | 1,215.5 | | | | |
| 3 | Налайх дүүрэг | 17 | 14,067.8 | 1 | 68.0 | 16 | 13,999.7 | 17 | 14,067.8 | | | | |
| 4 | Багахангай дүүрэг | 8 | 2,251.8 | - | - | 8 | 2,251.8 | 8 | 2,251.8 | | | | |
| 5 | Багануур дүүрэг | 16 | 3,589.7 | 2 | 40.6 | 14 | 3,549.0 | 16 | 3,589.7 | | | | |
| 6 | Чингэлтэй дүүрэг | 15 | 3,189.7 | 6 | 581.3 | 9 | 2,608.4 | 15 | 3,189.7 | | | | |
| 7 | Хан-Уул дүүрэг | 14 | 3,864.5 | 4 | 184.2 | 10 | 3,680.4 | 14 | 3,864.5 | | | | |
| 8 | Сонгинохайрхан дүүрэг | 12 | 15,413.6 | 2 | 853.5 | 10 | 14,560.0 | 12 | 15,413.6 | | | | |
| 9 | Баянгол дүүрэг | 12 | 1,435.0 | 2 | 51.8 | 10 | 1,383.2 | 12 | 1,435.0 | | | | |
| **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дүн** | | **105** | **45,033.5** | **22** | **1,831.1** | **83** | **43,202.4** | **105** | **45,033.5** | **-** | **-** | **-** | **-** |
| **Төсвийн шууд захирагч** | | | | | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар | 3 | 25,280.7 | 1 | 250.0 | 2 | 25,030.7 | 3 | 25,280.7 | | | | |
| 2 | Нийслэлийн Архивын газар | 5 | 101.7 | 2 | 17.7 | 3 | 84.0 | 5 | 101.7 | | | | |
| 3 | Нийслэлийн Аялал жуулчлалын газар | 2 | 0.1 | | | 2 | 0.1 | 2 | 0.1 | | | | |
| 4 | Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар | 3 | 247.4 | | | 3 | 247.4 | 3 | 247.4 | | | | |
| 5 | Нийслэлийн Дотоод аудитын газар | - | - | | | | | - | - | | | | |
| 6 | Нийслэлийн Замын хөгжлийн газар | 2 | 2.7 | | | 2 | 2.7 | 2 | 2.7 | | | | |
| 7 | Нийслэлийн Өмчийн харилцааны газар | - | - | | | | | - | - | | | | |
| 8 | Орон сууцны бодлогын газар | - | - | | | | | - | - | | | | |
| 9 | Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба | 3 | 6.2 | | | 3 | 6.2 | 3 | 6.2 | | | | |
| 10 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 3 | 10.7 | | | 3 | 10.7 | 3 | 10.7 | | | | |
| 11 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | - | - | | | | | - | - | | | | |
| 12 | Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар | - | - | | | | | - | - | | | | |
| 13 | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | 2 | 110.7 | 1 | 95.5 | 1 | 15.2 | 2 | 110.7 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Нийслэлийн Хяналт шалгалтын газар | 2 | 50.9 | 1 | 38.9 | 1 | 12.0 | 2 | 50.9 | | | | |
| 15 | Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар | 2 | 73.9 | 1 | 26.6 | 1 | 47.3 | 2 | 73.9 | | | | |
| 16 | Агро-сити эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын алба | 1 | 10.3 | 1 | 10.3 | | | 1 | 10.3 | | | | |
| 17 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | - | - | | | | | - | - | | | | |
| 18 | Улаанбаатар хотын нийтийн төв номын сан | 2 | 939.4 | | | 2 | 939.4 | 2 | 939.4 | | | | |
| 19 | Хүннү хотын Захирагчийн ажлын алба | 2 | 1,100.9 | 2 | 1,100.9 | | | 2 | 1,100.9 | | | | |
| 20 | Хот байгуулалт, хотын стандартын газар | 2 | 2,618.5 | | | 2 | 2,618.5 | 2 | 2,618.5 | | | | |
| 21 | Нийслэлийн Байгаль орчны газар | - | - | | | | | - | - | | | | |
| 22 | Улаанбаатар театр | - | - | | | | | - | - | | | | |
| 23 | Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газар | 4 | 38,162.8 | 1 | 10,641.7 | 3 | 27,521.1 | 4 | 38,162.8 | | | | |
| 24 | Нийслэлийн Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор | 1 | - | | | 1 | | 1 | - | | | | |
| 25 | Улаанбаатар хотын музей | - | - | | | | | - | - | | | | |
| 26 | Монголын хүүхдийн ордон | - | - | | | | | - | - | | | | |
| 27 | Хүүхдийн урлан бүтээх төв | - | - | | | | | - | - | | | | |
| 28 | Нийгмийн хамгааллын тусгай төв | - | - | | | | | - | - | | | | |
| | **Төсвийн шууд захирагчийн дүн** | **39** | **68,717.0** | **10** | **12,181.6** | **29** | **56,535.4** | **39** | **68,717.0** | | | | |
| | **Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар** | | | | | | | | | | | | |
| 1 | Улаанбаатар смарт карт | 2 | 38,456.5 | | | 2 | 38,456.5 | 2 | 38,456.5 | | | | |
| 2 | Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв ОНӨААТҮГ | - | - | | | | | - | - | | | | |
| 3 | Улаанбаатар түншлэл төв ХХК | 1 | 17.3 | 1 | 17.3 | | | 1 | 17.3 | | | | |
| 4 | Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК | - | - | | | | | - | - | | | | |
| 5 | Нийслэлийн Жижиг, дунд үйдвэр үйлчилгээг дэмжих төв НӨҮГ | 1 | 148.3 | | | 1 | 148.3 | 1 | 148.3 | | | | |
| 6 | Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ | - | - | | | | | - | - | | | | |
| 7 | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ | - | - | | | | | - | - | | | | |
| 8 | Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ | - | - | | | | | - | - | | | | |
| 9 | Нийслэлийн төр захиргааны авто бааз ОНӨААТҮГ | 4 | 16.6 | 1 | 12.8 | 3 | 3.8 | 4 | 16.6 | | | | |
| 10 | Нийслэлийн хот тохижилтын газар | - | - | | | | | - | - | | | | |
| 11 | Нийслэлийн Орон сууцны корпорац ХК | - | - | | | | | - | - | | | | |
| 12 | Нийслэлийн Соёлын төв өргөө ОНӨААТҮГ | 2 | 94.6 | | | 2 | 94.6 | 2 | 94.6 | | | | |
| 13 | Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК | 2 | 3,795.5 | | | 2 | 3,795.5 | 2 | 3,795.5 | | | | |
| 14 | Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ | - | - | | | | | - | - | | | | |
| 15 | Эмээлт эко аж үйлдвэрийн парк ОНӨААТҮГ | - | - | | | | | - | - | | | | |
| 16 | Бодлогын судалгаа шинжилгээний төв | - | - | | | | | 0 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК | 1 | 38.4 | | | 1 | 38.4 | 1 | 38.4 | | | | |
| 18 | Нэгдсэн төслийн удирдлагын газар | 1 | 4.6 | | | 1 | 4.6 | 1 | 4.6 | | | | |
| 19 | Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ | - | - | | | | | 0 | - | | | | |
| 20 | Дулааны тавдугаар цахилгаан станц ОНӨААТҮГ | 1 | 106.5 | | | 1 | 106.5 | 1 | 106.5 | | | | |
| 21 | КОП 17 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын газар ОНӨААТҮГ | - | - | | | | | 0 | - | | | | |
| 22 | Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ | 2 | 4,770.8 | | | 2 | 4,770.8 | 2 | 4,770.8 | | | | |
| 23 | Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ | - | - | | | | | 0 | - | | | | |
| 24 | Улаанбаатар орон сууцжуулалт ХХК | 2 | 45.3 | 1 | 39.1 | 1 | 6.2 | 2 | 45.3 | | | | |
| 25 | Асгат хүнс ОНӨААТҮГ | 1 | 127.8 | 1 | 127.8 | | | 1 | 127.8 | | | | |
| 26 | Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК ХХК | 4 | 3,116.8 | | | 4 | 3,116.8 | 4 | 3,116.8 | | | | |
| 27 | Олон улсын худалдаа логистикийн төв ХК | - | - | | | | | 0 | - | | | | |
| 28 | Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК | - | - | | | | | 0 | - | | | | |
| 29 | Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ | 1 | 1,475.5 | | | 1 | 1,475.5 | 1 | 1,475.5 | | | | |
| 30 | Улаанбаатар лифт ОНӨААТҮГ | 1 | 60.8 | 1 | 60.8 | | | 1 | 60.8 | | | | |
| 31 | Улаанбаатар спорт менежмент ХК | - | - | | | | | 0 | - | | | | |
| 32 | Улаанбаатар такси каб ХХК | 2 | 3.1 | | | 2 | 3.1 | 2 | 3.1 | | | | |
| 33 | Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк ХК | - | - | | | | | 0 | - | | | | |
| 34 | Багачуул хүнс ОНӨААТҮГ | - | - | | | | | 0 | - | | | | |
| 35 | Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК | 2 | 400.8 | | | 2 | 400.8 | 2 | 400.8 | | | | |
| 36 | Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төв ОНӨААТҮГ | - | - | | | | | 0 | - | | | | |
